

ТОСОН УУЛ ХИХ ГЭРЭЭТ ТАЛБАЙН ТАЛААР
МОНГОЛ ГАЗРЫН ТОС (МГТ) КОМПАНИ БОЛОН
МЕДАЛЛИОН МОНГОЛ ОИЛ КОМПАНИЙН (ММО)
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
ХУВААХ ТУХАЙ
Г Э Р Э Э

1993 оны 4 дүгээр сарын 26

ГАРЧИГ

Агуулга	Хуудас
УДИРТГАЛ	6
ЗҮИЛ 1. Төлөөлөгчид	6
1.1. Төлөөлөгчид томилох	6
1.2. Засгийн газрын төлөөлөгчийн нэвтрэх эрх	6
ЗҮИЛ II. Тодорхойлолтууд	7
2.1. Нэр томъёо	7
2.2. Тодорхойлолтууд	7
ЗҮИЛ III. Эрх олгох тухай	14
ЗҮИЛ IV. Өртөг зардал	14
ЗҮИЛ V. Хугацаа	
5.1. Хайгуулын үе	15
5.2. Хайгуулын хугацааг сунгах	15
5.3. Нээлтийн цооногууд	15
5.4. Үр ашигтай нээлтүүд	16
5.5. Олборлолтын хугацаа	16
5.6. Үнэлгээний хөтөлбөр, олборлолтын төлөвлөгөө болон холбогдох талбайг хянах	16
5.7. Олборлолтын хугацааг сунгах	17
ЗҮИЛ VI. Хайгуулын ажил	17
6.1. Ажил үүргийн наад захын хариуцлага	17
6.2. Өрөмдөх аргууд	22
6.3. Давуулан гүйцэтгэсэн ажлыг шилжүүлэн тооцох тухай	22
6.4. Хайгуулын ажлын хөтөлбөр ба төсөв	22
ЗҮИЛ VII. Талбай буцааж өгөх	
7.1. Үнэлгээний талбай ба үр ашигтай нээлт	23
7.2. Гэрээ ёсоор талбайг буцааж өгөх	

7.3. Өөрийн хүсэлтээр буцааж өгөх	23
ЗҮЙЛ ҮШ. Төлбөр ба бүтээгдэхүүн хуваалт	24
8.1. Төлбөр (роялти)	24
8.2. Өртөгт тос	24
8.3. Хуваах тос	25
8.4. Өртөгт тосны үнэлгээ	26
8.5. Үйлдвэрлэлийн урьдчилсан тооцоо	26
8.6. Дуталт ба хэтрүүлэлт	27
ЗҮЙЛ 1Х. Хийн бүтээгдэхүүн хуваалт	27
9.1. Хийн зах зээл	27
9.2. Хийн бөрлуулалт ба бүтээгдэхүүн хуваалт	27
9.3. Хийн тэнцлийн хэлэлцээр	28
9.4. Үнэлгээний ба олборлолтын төлөвлөгөө	28
ЗҮЙЛ Х. Урамшуулал, татвар, газрын түрээс ба захиргааны шимтгэл	29
10.1. Урамшуулал	29
10.2. Урамшуулал өгөх бусад тохиолдол	29
10.3. Урамшуулал төлөх	29
10.4. Орлогын татвар	29
10.5. Газрын түрээс	31
10.6. Захиргааны шимтгэл	32
ЗҮЙЛ Х1. Хэмжилт	32
11.1. Бүтээгдэхүүн хуваах хэмжилт	33
11.2. Хэмжилтийг залруулах	34
11.3. Хэмжилтийн бүртгэл	34
ЗҮЙЛ ХП. Техникийн мэдээлэл	34
12.1. Техникийн ерөнхий бүртгэл	34
12.2. Геофизикийн мэдээлэл	34
12.3. Геологи, петрофизик болон үйлдвэрлэлийн сорилтын мэдээлэл	34
12.4. Тайлал хийсэн мэдээлэл, газрын тос ба хийн нөөцийн тайлангууд	35

12. 8. Нууцлал	36
ҮИЛ XIII. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл	36
13. 1. Нягтлан бодох бүртгэл	36
13. 2. Нягтлан бодох бүртгэлийн тэилян	36
ҮИЛ XIV. Засгийн газрын дэмжлэг туслалцаа	37
14. 1. Нийтлэг дэмжлэг туслалцаа	37
ҮИЛ XV. Өмчийг эзэмших ба өмчлөх	37
ҮИЛ XVI. Гаалийн татвараас чөлөөлөл	38
16. 1. Гэрээлэгчийн гаднаас оруулах ажил	38
16. 2. Ажиллагсадын гаднаас оруулах ажил	38
16. 3. Монголд эдэлгээгээс хасардсан ажил	38
16. 4. Экспорт	39
ҮИЛ XVII. Валютын солилцооны эрх	39
17. 1. Гадаад валют	39
17. 2. Гаднадын банкны дахь данс	39
17. 3. Валют солих эрх	39
17. 4. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх төлбөр	40
17. 5. Оролцон гүйцэтгэгч	40
ҮИЛ XVIII. Монголын гэрээлэгчид, материал болон ажиллагсад	40
ҮИЛ XIX. Онцгой төхөөрөлдөл	41
19. 1. Газрын төстэй холбогдсон үйл ажиллагааны гарт ороох онцгой төхөөрөлдөл	41
19. 2. Үндэсний онц байдал	42
ҮИЛ XX. Давагдаагүй хүчин зүйл	42
ҮИЛ XXI. Гэрээ цуцлах	43
ҮИЛ XXII. Арбитр	44
ҮИЛ XXIII. Мэдэгдэл	46
ҮИЛ XXIV. Эрх шилжүүлэлт	47
ҮИЛ XXV. Ерөнхий заалт	48
25. 1. Хансралтууд	48
25. 2. Хуулиуд	48
25. 3. Санхүүжилт	48
25. 4. Гэрээний хэл	48

ХАВСРАЛТУУД:

Хавсралт А - Гэрээт талбайн зураг	
Хавсралт В - Талбайн тодорхойлолт	
Хавсралт С - Тооцооны журам	49
ЗҮЙЛ 1. Ерөнхий заалтууд	49
1.1. Зорилго	49
1.2. Нэр томъёо	49
1.3. Баримт бичгийн давамгайлах байдал	49
1.4. Үйл ажиллагааны тухай тайлан мэдээ	49
1.5. Залруулга ба шалгах	50
1.6. Валют солих	50
ЗҮЙЛ II. Өртөг, зардал	51
2.1. Нөхөн төлөгдөх зардал	51
2.2. Тооцооны үндэс	55
ЗҮЙЛ III. Эд хөрөнгийн тооллого	56
3.1. Тооллого хийх, мэдэгдэх, төлөөлөх	56
3.2. Эд хөрөнгийн бүртгэлийг тулган шалгаж зохицуулах	56
Хавсралт Д - Газрын түрээс ба захиргааны шимтгэл	59
Хавсралт Е - Татварыг хэрэгжүүлэх нөхцөлүүд	57

Энэхүү Гэрээг Монгол Улсын Монгол газрын тос (МГТ) компани, Медаллион Монгол Ойл (ММО) компани (Гэрээлэгч)-ийн хооронд 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулав.

У Д И Р Т Г А Л

Монгол улс нутаг дэвсгэрийнхээ байгалийн бүх нөөц баялгийн цорын ганц эзэмшигч бөгөөд монголын ард түмний ашиг сонирхолд нийцүүлэн байгалийн нөөц баялгаа олборлон боловсруулж, ашиглах эрхтэй.

Монгол улс энэхүү гэрээнд тодорхойлсон гэрээт талбайд газрын тос хайх, олборлох, боловсруулах ажиллагааг хөхүүлэн дэмжихийг эрмэлзэж байна.

Гэрээлэгч гэрээт талбайд газрын тос хайх, олборлох, боловсруулах онцгой эрх эдэлнэ.

Гэрээлэгч энэ гэрээ ёсоор газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүү, техникийн болон мэргэжлийн чадвартай болно.

МГТ компани нь Газрын тосны хэрэг эрхлэх байгууллагын үүргийг гүйцэтгэнэ. МГТ компанийн ерөнхий захирал нь Монгол улсын нэрийн өмнөөс хэлэлцээ хийж, энэ гэрээг хэрэгжүүлэх эрх мэдэлтэй.

Энэхүү гэрээнд тусгагдсан харилцан тохиролцоог иш үндэс болгож, дараах зүйлсийг үүгээр тохиролцлоо.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ТӨЛӨӨЛӨГЧИД

1.1. Төлөөлөгч томилох

а. Монгол улс энэ гэрээ ёсоор өөрийн төлөөлөгч (Засгийн газрын төлөөлөгч)-ээр МГТ компанийн ерөнхий захирлыг буюу түүнийг орлох этгээдийг үүгээр томилж байна.

б. Гэрээлэгч энэ гэрээ ёсоор өөрийн төлөөлөгч (Гэрээлэгчийн төлөөлөгч) - өөр Х. С. Финкелштейн буюу түүнийг орлох этгээдийг үүгээр томилж байна.

в. Засгийн газрын төлөөлөгч буюу гэрээлэгчийн төлөөлөгчийг энэ гэрээний ХХШ зүйлд заасны дагуу нөгөө талдаа мэдэгдэл өгөх замаар өөрчилж болно.

1. 2. Засгийн газрын төлөөлөгчийн нэвтрэх эрх

а. Засгийн газрын төлөөлөгч гэрээт талбайд нэвтрэх болон газрын тостой холбогдсон бүхий л үйл ажиллагаатай танилцах эрхтэй бөгөөд гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчид энэ эрхээ хэрэгжүүлэхийг хүссэн цагт нь зохих тусламжийг үзүүлж байна. Гэхдээ энэхүү 1. 2-т заасан аливаа үйлдэл нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд буюу хувь хүний аюулгүй байдалд зохисгүйгээр нөлөөлөх өсгүй.

б. Гэрээлэгч нь Монгол улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөлөгчид гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай танилцах боломж олгоно.

ХОЕРДУГААР ЗҮЙЛ ТОДОРХОЙЛОЛТУУД

2. 1. Нэр томъёо

Энд тодорхойлсон зүйл, анги нь зөвхөн энэ гэрээнд хэрэглэгдэнэ. Зүйл, анги гэсэн нэр томъёог ижил утгатай хэрэглэнэ.

2. 2. Тодорхойлолтууд

Хэрэв агуулга нь өөр утга санаагаар тодорхой ойлгогдохгүй байвал энэхүү гэрээний дараах нэр томъёонууд нь II зүйлд дурдсан агуулгатай байх бөгөөд түүнээс урган гарах бүх ухагдахуун болон ийм нэр томъёонуудын бусад хэлбэрүүд нь энд дурдсан агуулгатай

байх болно.

Нэр томъёо нь энд өөрөөр тодорхойлогдоогүй бол газрын тосны тухай хуульд заасан нэр томъёоны утгыг илэрхийлнэ.

"Дагалдах бодис" гэж газрын тос ба байгалийн хийгээс гаргаж авсан буюу тэдгээртэй холбоотой бусад аливаа төрлийн бодис хийгээд тэдгээрээс гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хэлнэ.

"Газрын тос" гэж газрын хэвлийд байгаа хамтад нь буюу дангаар нь олборлож болох шингэн тос, хийн буюу хатуу байдалтай нүүрс-устөрөгчийн төрөл бүрийн нэгдлийг хэлнэ.

"Гэрээ" гэдэг нь МГТ компани болон Медаллион Монгол ойл компанийн Тосон уул Х1Х гэрээт талбайн талаар байгуулсан энэ гэрээг хэлнэ.

"Газрын тосны тухай хууль" гэж 1991 оны хоёрдугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Газрын тосны тухай хуулийг хэлнэ.

"Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа" гэж газрын тос хайх, олборлох, боловсруулах, тээвэрлэх, хадгалах ба борлуулахтай холбоотой ажиллагааг хэлнэ.

"Газрын тосны хэрэг эрхлэх байгууллага" гэж Монгол газрын тос (МГТ) компанийг хэлнэ.

"Гэрээлэгч" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар МГТ компанитай гэрээ байгуулсан Медаллион компани буюу түүний томилсон этгээд болон дээрх үйл ажиллагааны аль нэг хэсгийг хэрэгжүүлэх эрх олгогдсон аль нэг этгээдийг хэлнэ.

"Хувь нийлүүлэгч" гэж дараах тохиолдолд гэрээлэгчийн хувьд аливаа корпораци, хувь хүмүүс буюу хуулийн бусад этгээдийг хэлнэ.
Үүнд:

1. Хувьцааныхаа тавь (50) буюу түүнээс дээш хувийг эсвэл санал хураалтаар шийдвэрлэх өмчийнхөө хүүг гэрээлэгчид эзэмшүүлсэн аль нэг корпораци буюу хуулийн бусад этгээд,

2. Гэрээлэгчийн хувьцааны тавь (50) буюу түүнээс дээш хувь эсвэл санал хураалтаар шийдвэрлэдэг өмчийн хүүг эзэмшигч аль нэг корпораци буюу хуулийн этгээд,

"Оролцон гүйцэтгэгч" гэж газрын тостой холбогдсон үйл

ажиллагаа явуулахаар гэрээлэгчийн хөлслөн авсан монголын буюу гадаадын аливаа компани буюу хувь хүнийг хэлнэ.

"Нэгж талбай" гэж уртрагийн 10 минут, өргөргийн 10 минуттай тэнцэх хэмжээний газрыг хэлнэ.

"Үнэлгээний талбай" гэж үнэлгээний хөтөлбөрийн дагуу судлах нь зүйтэй гэж гэрээлэгчийн үзсэн геологийн нэг буюу хэд хэдэн бүтэц буюу илрэлийг хэлнэ.

"Үнэлгээний хөтөлбөр" гэж үнэлгээний цооногуудыг өрөмдөж, үнэлэлт өгөх ажлын төлөвлөгөө, төсвийг хэлнэ.

"Баррель" гэж 1,01325 барын агаарын даралтын дор, Фаренгейтийн 60 хэмийн дулаанд буй 158,987 литр шингэний эзэлхүүний хэмжээг хэлнэ.

"Хуанлийн хагас жил" гэж хуанлийн 1 дүгээр сарын 1-нд эхэлж, 6 дугаар сарын 30-нд дуусдаг жилийн эхний хагасыг, эсвэл 7 дугаар сарын 1-нд эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусдаг жилийн сүүлийн хагасыг тус тус хэлнэ.

"Хуанлийн сар" гэж Грегорийн хуанлийн 12 сарын нэг нь бөгөөд тухайн сарын анхны өдрөөс эхэлж, сүүлчийн өдрийг дуустал үргэлжлэх хугацааг хэлнэ.

"Хуанлийн жил" гэж Грегорийн хуанлийн 1 дүгээр сарын 1-нд эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусдаг хугацааг хэлнэ.

"Ашиглалтын талбай" гэж гэрээт талбай дахь үр ашигтай нээлт бүхий талбайг хэлнэ.

"Талбай буцааж өгөх" гэж хайгуулын ажлын тодорхой үе шатанд гэрээлэгчээс өөрийн хүсэлтээр, эсвэл гэрээ ёсоор гэрээт талбайн тодорхой хэсгийг буцааж өгөхийг хэлнэ.

"Орд" гэж нэг буюу хэд хэдэн цооногоор илрүүлсэн геологийн бүтцээрээ болон давхарга зүйн онцлогоороо төсөөтэй бөгөөд газрын тос олборлож болох нэг буюу хэд хэдэн байгалийн агууламж бүхий талбайг хэлнэ.

"Түүхий тос" гэж газар доорхи байгалийн агууламжид байгаа эсвэл гадаргуу дээр ялгагч болон боловсруулах бусад төхөөрөмжөөр оруулан гаргасны дараа агаарын даралтад, шингэн байдалд буй нүүрс-устөрөгчийг хэлнэ. Түүнчлэн түүхий тосод байгалийн барагшин, конденсат хийгээд ялгагч үйлдвэр, эсвэл боловсруулах

ec-ll
1/11

бусад төхөөрөмжид шингэрүүлсэн байгалийн шингэн хий багтана.

"Хэлбэлзэх зэрэглэл" гэж МГТ компани гэрээлэгчийн хооронд хуваах ашигт тосны хэмжээ, хувийг өдөрт олборлох бүтээгдэхүүний дундаж хэмжээтэй уялдуулан тооцоолох аргачлалыг хэлнэ.

"Гүйцэтгэгч" гэж МГТ компанитай байгуулсан гэрээний үндсэн дээр газрын тостой холбогдсон үйл ажиллагааны аливаа хэсгийг гүйцэтгэх хуулийн этгээдийг хэлнэ.

"Газрын тосны дүрэм" гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой төрлийг гүйцэтгэх явцад мөрдөх аргачлал, горимыг хэлнэ.

"Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх" гэж гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд гэрээт талбайн хүрээнд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах гэрээлэгчийн эрхийг хэлнэ.

"Үр ашигтай нээлт" гэдэг нь гэрээлэгчийн тооцоолсон олборлох нөөц, газрын тосны үнэ, олборлолтын зардал зэргийг оролцуулсан техник-эдийн засгийн зохих хүчин зүйлсийг харгалзан үр ашигтайгаар олборлох боломжтой гэж гэрээлэгчийн тогтоосон нэг эсвэл хоёр (2) түүнээс дээш тооны байгалийн агууламжийг хэлнэ.

"Гэрээт талбай" гэж энэ гэрээний "А" хавсралтад зурж үзүүлсэн, "Б" хавсралтад тодорхойлсон Тосон уул Х1Х талбайг хэлэх бөгөөд тэр талбай 7 дугаар зүйлд заасны дагуу буцааж өгөх хэмжээгээр тухай бүр багасч байна.

"Гэрээт түүхий тос" ба "Гэрээт хий" гэж энэ гэрээний дагуу гэрээт талбайгаас олборлож хуримтлуулсан түүхий тос ба хийг хэлнэ. Энэ нэр томъёог тайлбарлах үүднээс "Олборлосон" гэдэг нь гадаргуу дээр гаргаж, бүтээгдэхүүн хуваах хэмжүүрийн хэрэгслээр нэвтрүүлсэн, "Хуримтлуулсан" гэдэг нь гэрээнд оролцогч аль нэг талаас авч ашиглах боломж бүрдүүлснийг хэлэх бөгөөд харин: 1. Гэрээт талбайн хүрээнд гадаргууны доорхи давхарга руу шахах оруулсан, 2. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа (түлш, хоолой дүүргэх, эсвэл бусад хэлбэрээр) -нд ашигласан, 3. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад (шатаах, гоожих, багасах, уурших замаар, ослоор, эсвэл бусад байдлаар) хорогдсоныг тооцохгүй.

"Гэрээт улирал" гэж Грегорийн хуанлийн дагуу энэ гэрээ хүчин,

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дараалсан гурван (3) сарын хугацааг хэлнэ.

"Гэрээт жил" гэж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэх аливаа жил эсвэл нэг жилийн хугацааг хэлнэ.

"Төлбөр (роялти)" гэж Монгол улсын Газрын хэвлийн хууль болон Газрын тосны тухай хуулийн дагуу байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөрийг хэлнэ.

Энэ төлбөрийг олборлосон нийт бүтээгдэхүүнд ногдуулж, өртөг тосыг хуваарилахаас өмнө төлнө.

"Өртөгт тос" гэж гэрээлэгчийн өртөг зардлыг нөхөхөд зориула түүхий тосны хэмжээг хэлнэ.

"Үр ашигтай үйлдвэрлэл эхэлсэн өдөр" гэж орд бүрийн хуви түүхий тосны нийт олборлолт нь хуримтлуулах ёстой нийт хэмжээни доод хязгаарт хүрсэн өдрийг хэлнэ. Хуримтлуулах ёстой ний хэмжээний доод хязгаарыг МГТ компани, гэрээлэгч хоёр тохиролцоно.

"Олборлолтын зардал" гэдэг нь олборлолтын үйл ажиллагаата холбогдон гарах нийт зардал (ашиглалтын зардал орохгүй) -ыг хэлнэ.

"Ашиглалтын зардал" гэж газрын тосны үйлдвэрлэлт боловсруулалт, тээвэрлэлт, хадгалалт болон борлуулалтта холбоотой зардлыг хэлнэ.

"Олборлолтын үйл ажиллагаа" гэж нэг буюу түүнээс дээш тоон үр ашиг бүхий нээлттэй холбогдуулан хийх хөрөнгө оруулалт зориулалттай бүхий л үйл ажиллагааг хэлэх бөгөөд тэдгээрт дараа үйл ажиллагаа багтана:

-олборлолтын цооног ерөмдөх, ажиллуулах, дамжуулах хоолой, үйлдвэр, түгээгүүр, бусад байгуула барьж байгуулах, ажиллуулах,

-газрын тос ялгах, баяжуулах, уснаас ялгах, шаха шингэрүүлэх, хадгалах, шатаах, тээвэрлэх болон бусад байдла боловсруулж ашиглах,

-дахин шахаж эргэлт, даралтанд оруулах, олборлолт нэмэгдүүлэх хоердогч, гуравдагч болон бусад үйл ажиллагаа болно.

"Ашиглалтын төлөвлөгөө" гэж үр ашигтай нээлттэй холбоо бүх олборлолтын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлнэ.

"Нээлтийн цооног" гэж газрын тосны нөөц нь бүр

ML

нотлогдоогүй байгалийн агууламжийг нээсэн цооногийг хэлэх бөгөөд уг байгалийн агууламж нь үр ашигтай нээлт болох эсэхийг тогтоох зорилгоор цаашид судлах шаардлагатай гэж гэрээлэгч үзсэн цооногийг хэлнэ.

"Хүчин төгөлдөр болсон өдөр" гэж Монгол улсын Засгийн газраас энэхүү гэрээг баталсан он, сар, өдрийг хэлнэ.

"Хайгуулын зардал" гэж хайгуулын үйл ажиллагаатай холбогдон гарсан нийт зардал (ашиглалтын болон олборлолтын зардал орохгүй) - ыг хэлэх бөгөөд дараах үйл ажиллагаа багтана. Үүнд:

- 1. Үр ашигтай нээлтэд багтах эсэх нь тухайн үед тогтоогдоогүй нэг буюу хэд хэдэн байгалийн агууламжийг нээн илрүүлэх, эсвэл
- 2. Үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

"Хайгуулын үйл ажиллагаа" гэж агаарын ба геологи, геофизикийн зураглал хийх, тэсэлгээ хийх, керн авах, давхарга зүйг судлах, хайгуулын болон үнэлгээний цооног өрөмдөх, мэдээлэлд тайлал хийх болон дээрхтэй холбоотой бусад бүх үйл ажиллагааг хэлнэ.

"Хайгуулын үе" гэж нэг буюу хэд хэдэн гэрээт жилийн хугацааг хэлэх бөгөөд энэ хугацаанд гэрээлэгч нь энэхүү гэрээний дагуу баталгаат эрхтэй байна.

"Хайгуулын хугацаа" гэж хайгуулын үетэй адил байна.

"Хайгуулын ажлын хөтөлбөр" гэж хайгуулын үед гэрээлэгчийн гүйцэтгэх, 6.1 зүйлд тусгасан наад захын ажил үүргийг багтаасан хайгуулын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлнэ.

"Орлогын татвар" гэж Монгол улсын хуулийн дагуу ногдуулах, эсвэл орлого буюу ашгийн хэмжээгээр тогтоох бүх татварыг хэлэх бөгөөд энэ нь татвар, орлогын болон экспортын татвар, төлбөр, хураамж зэрэг ямар ч нэр томъёотой байхаас үл хамаарна.

"Экспорт эхлэх үр ашигтай үйлдвэрлэл" гэж үр ашигтай нээлтийн хувьд гэрээлэгчийн хуваарьт гэрээт түүхий тос буюу гэрээт хийг экспортлох буюу Монгол улсын хилийн чанадад худалдахаар тогтмол гүйцэтгэх анхны ачуулалтын эхэлсэн өдрийг хэлнэ.

"Хуулийн этгээд" гэж Засгийн газрын хууль тогтоомжоор хуулийн этгээд болохыг нь хүлээн зөвшөөрсөн аливаа корпораци, компани, хамтарсан үйлдвэр болон бусад этгээдийг хэлнэ.

"Хууль тогтоомж" гэж дагаж мөрдөж буй эсвэл энэ гэрээг байгуулсны дараа хүчин төгөлдөр болох холбогдох аливаа хууль, бусад эрхийн актыг хэлнэ.

"Байгалийн хий" гэж агаарын даралт, температурын хэвийн нөхцөлд хийн байдалд байгаа нүүрс-устөрөгчийг хэлэх бөгөөд үүнд хүнд ба хөнгөн эрдэслэг хий, газрын тосны олборлолтын хий болон хүнд эрдэслэг хийгээс шингэн нүүрс-устөрөгчийг ялгах буюу түүнээс гаргаж авсны дараа үлдэх хий, түүнчлэн шингэн буюу хийжүүлсэн нүүрс-устөрөгчтэй хамтад нь гаргаж авсан нүүрс-устөрөгчийн бус хий тус тус багтана.

"Бүтээгдэхүүн хуваах хэмжилт" гэж 11 дүгээр зүйлд заасныг хэлнэ.

"Хуваах тос" гэж олборлосон нийт тосноос төлбөр (роялти) болон өртөгт тосыг хасаад үлдэх хэсгийг хэлнэ.

"Улирал" гэж Грегориин хуанлийн улирлыг хэлэх бөгөөд энэ нь нэгдүгээрт 1, 2, 3 дугаар сар, хоёрдугаарт 4, 5, 6 дугаар сар, гуравдугаарт 7, 8, 9 дүгээр сар, дөрөвдүгээрт 10, 11, 12 дугаар сар тус тус болно.

"Татварууд" гэж Монгол улсын Албан татварын хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу аливаа хуулийн этгээд буюу бусад этгээд, эд хөрөнгө, гүйлгээ буюу үйл ажиллагаанд ногдуулсан бүх татвар (орлогын татварыг оруулахгүй)-ыг хэлнэ.

"Зөвлөгч" гэдэг нь газрын тос, хий хайх, олборлох ба бүтээгдэхүүн гаргахтай холбоотой бүхий л асуудлаар МГТ компанид зөвлөх, туслах, үйлчилгээ үзүүлэхээр МГТ компанитай гэрээ байгуулсан аливаа хувь хүн, байгууллага, компани эсвэл бусад хуулийн этгээдийг хэлнэ.

"Жил" гэж тухайлан заасан он, сар, өдрөөс эхлэн тооцох Грегориин хуанлийн дараалсан 12 сарын хугацааг хэлнэ.

Handwritten initials or signature.

ГҮРАВДУГААР ЗҮЙЛ
ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Гэрээлэгч нь гэрээт талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах онцгой эрх олж авах хүсэлтээ МГТ компанид гаргасан болно. Дээрхийг үл харгалзан гэрээлэгчид дараах эрхийг олгож болно. Үүнд:

-дамжуулах хоолой, зам, гүүр, түгээх станц, сууц, агуулах нисэх онгоц буух талбай, радио цамхаг ба сансрын холбооны төхөөрөмж зэргийг барьж байгуулах,

-гэрээт талбайд үйлдвэрлэсэн аливаа газрын тосыг газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд ашиглах,

-газрын тосыг гэрээт талбайгаас худалдах буюу экспортод гаргах цэг хүртэл тээвэрлэх,

-энэ тосыг хадгалах, түгээх,

-хуваах тосны гэрээлэгчид ногдох хэсгийг (монголд болон гадаадад) ашиглах, эсвэл худалдах,

-хуваах тосыг худалдсанаас буюу бусад хэлбэрээр зарцуулснаас олох бүх орлогыг гадаадад гуйвуулах буюу үлдээх болон түүнийг чөлөөтэй зарцуулах,

Энэхүү гэрээнд тусгагдсан бусад бүх эрхийг эдлэх зэрэг болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ
ӨРТӨГ ЗАРДАЛ

Гэрээнд еерөөр заагаагүй бол газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх өртөг, зардлыг гэрээлэгч хариуцна. Хэрэв газрын тостой холбогдсон үйл ажиллагааны үр дүнд үр ашигтай нээлт хийвэл уг үйл ажиллагаатай холбогдон гарсан өртөг зардлыг гэрээлэгч энэ гэрээний дагуу нөхөж авч болно. Энэ гэрээнд оролцогч аль ч тал ямар нэгэн ийм нээлт хийнэ гэсэн баталгаа гаргахгүй бөгөөд хэрэв нээлт хийвэл түүнийг үр ашигтай болно гэдэг баталгаа гаргахгүй. Тийм учраас энэхүү гэрээний дагуу

үүсэх аливаа өртөг зардлыг гэрээлэгч нөхөж авах баталгаа мн байхгүй.

ТАВДУГААР ЗҮЙЛ ХУГАЦАА

5.1. Хайгуулын үе

Хайгуулын анхны үе нь тав (5) хүртэл жил байна. Хайгуулын анхны үе нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлнэ. Хайгуулын анхны үеийн эхний болон хоёрдахь шат тус бүр хоёр (2) жил байна. Гуравдахь шат нь нэг (1) жил байна.

5.2. Хайгуулын хугацааг сунгах.

а. Хэрэв гэрээлэгч нь хайгуулын ажлын хөтөлбөр дуусахаас наа зах нь гуч (30) хоногийн өмнө хайгуулын хугацааг сунгах саналаа МГТ компанид бичгээр өгвөл МГТ компани нь хайгуулын хугацааг сунгах асуудлыг авч үзнэ.

б. МГТ компани нь гэрээлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэндээ хайгуулын хугацааг хоёр удаа хоёр (2) жилийн хугацаагаар сунгаж болно.

в. Хэрэв хайгуулын гуравдахь үе буюу эсвэл сүүлчийн сунгасан хугацаа дуусах өдөр үр ашигтай болох нь тодорхой болоогүй нээлтийн цооног байгаа бол уг нээлтийн цооног байгаа үнэлгээний талбайн хувьд хайгуулын эцсийн сунгасан хугацаа нь дараах нөхцөлүүдийн аль нэг нь түрүүлж тохиолдох хүртэл хүчин төгөлдөр үргэлжилнэ. Үүнд:

1. тухайн нээлтийг үр ашигтай нээлт гэж тогтоох,
2. тухайн нээлтийг үр ашигтай биш нээлт гэж тогтоох, эсвэл
3. хайгуулын гуравдахь ба эцсийн хугацаа дуусах ёстой өдрөөс хойш нэг (1) жил өнгөрөх зэрэг болно.

г. Хайгуулын хугацаа болон аливаа үе шатыг давагдашгүй хүчин зүйл тохиолдсон хугацаагаар сунгана.

5.3. Нээлтийн цооногууд

а. Хэрэв аливаа цооногийг нээлтийн цооног гэж тогтоовол,

гэрээлэгч 15 хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид энэ тухай мэдэгдэх бөгөөд ингэж мэдэгдсэн өдөр нь тухайн нээлтийн цооногийг бүртгэсэн өдөр болно.

б. Нээлтийн цооног бүрийг бүртгэсэн өдрөөс хойш ер (90) хоногийн дотор гэрээлэгч Засгийн газрын төлөөлөгчид дараах мэдээллийг өгнө. Үүнд:

1. Үнэлгээний хөтөлбөр ба төсөв

2. Үнэлгээний талбайн зураг, бусад тодорхойлолтыг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгөх бөгөөд үнэлгээний хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлнэ.

5.4. Үр ашигтай нээлтүүд

а. Хэрэв нэг буюу хэд хэдэн нээлтийн цооногоор илрүүлсэн нэг буюу хэд хэдэн нээлт нь үр ашигтай нээлт гэж тогтоогдвол гэрээлэгч 15 хоногийн дотор Засгийн газрын төлөөлөгчид энэ тухай мэдэгдэх бөгөөд ингэж мэдэгдсэн өдөр нь тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдөр болно.

б. Үр ашигтай нээлт бүрийг бүртгэснээс хойш нэг зуун наяд (180) хоногийн дотор гэрээлэгч Засгийн газрын төлөөлөгчид дараах зүйлийг өгнө:

1. олборлолтын төлөвлөгөө ба төсөв,

2. олборлох нэг буюу хэд хэдэн талбайн зураг ба бусад тодорхойлолтыг гаргаж өгнө.

Монгол газрын тос (МГТ) компани болон гэрээлэгч тохиролцсоны дагуу олборлох төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхэлнэ.

5.5. Олборлолтын хугацаа

Хайгуулын хугацаа аяндаа дууссан буюу түүнийг бусад хэлбэрээр зогсоосон эсэхийг үл харгалзан энэ гэрээ үр ашигтай нээлт нэг бүрийн хувьд, тухайн үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс хойш 20 жилийн хугацаа (олборлолтын хугацаа)-нд хүчин төгөлдөр хэвээр байна.

5.6. Үнэлгээний хөтөлбөрүүд, олборлолтын төлөвлөгөөнүүд болон холбогдох талбайнуудыг хянах тухай

Энэ гэрээний бусад заалтыг үл харгалзан гэрээлэгч нь нэмэлт мэдээлэл, судалгааны үндсэн дээр аливаа үнэлгээний хөтөлбөр, үнэлгээний талбай, олборлолтын төлөвлөгөө болон үр ашигтай нээлтийн хүрээндэх нэг буюу хэд хэдэн талбайн талаар гэрээлэгчийн хийсэн тодорхойлолтыг үе үе хянан өөрчилж болно. Гэхдээ ийнхүү хянахаас өмнө ҮП зүйлийн дагуу нэгэнт буцааж өгсөн гэрээт талбайн аль нэг хэсгийг үнэлгээний талбай эсвэл үр ашигтай нээлтэд оруулж болохгүй.

Гэрээлэгч нь хяналт буюу өөрчлөлтийг хэлэлцүүлэхээс арван тав (15) хоногийн өмнө Засгийн газрын төлөөлөгчид мэдэгдэнэ.

5.7. Олборлолтын хугацааг сунгах

Олборлолтын хугацаа дуусахаас наад зах нь жар (60) хоногийн өмнө гэрээлэгчээс бичгээр гаргасан хүсэлтийн дагуу газрын тосны үйл ажиллагааны үйлдвэрлэлийн дэд бүтцийг барьж байгуулах, гүйцэтгэх ажлын хэмжээг харгалзан олборлолтын хугацааг дахин тав, таван жилийн хугацаагаар хоёр удаа сунгаж болно.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ ХАЙГУУЛЫН АЖИЛ

6.1. Наад захын ажил үүрэг

Гэрээлэгч нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг зуун хорь (120) хоногийн дотор хайгуулын үйл ажиллагааг эхлэх бөгөөд дор тодорхой заасан наад захын ажил үүргийг хүлээнэ. Энэ гэрээнд заасан хайгуул хийх хугацаа тус бүрд ногдох дор тодорхойлсноос багагүй хэмжээний зардлыг гаргана.

Хайгуулын эхний үеийн наад захын ажил үүрэг

1 үе шат. Эхний болон хоёрдахь жил

А. Ажил үүрэг-Эхний жил

Тооцоолсон өртөг: [] ам. доллар

1. "Монголын газрын тосны хэтийн төлөв"-ийн талаархи МГТ, ЗАИТ компанийн тайланг худалдан авах [] ам. доллар

2. МГТ компанийн геологи, геофизикийн мэдээлэлтэй танилцах (худалдаж авах) - [] ам. доллар

3. Хиймэл дагуулаас авсан гэрээт талбайн 1:1 000 000 хэмжээтэй фото-геологийн зураг худалдаж авах [redacted] ам. доллар

4. Тамсагийн сав газарт Эл Си Ти\МГТ компанийн хийсэн хүндийн хүч болон агаарын соронзон зургийг худалдан авах - [redacted] ам. доллар

5. Дорнод Монгол-Тамсагийн сав газарт Эс Эс Ай, МГТ компанийн хийсэн тунамал хурдаст сав газрын судалгааны тайланг худалдаж авах - [redacted] ам. доллар

6. Гэрээт талбайд хээрийн судалгаа хийж, геологийн дээж цуглуулах - [redacted] ам. доллар

7. Гэрээт талбайд Вестерн Жеофизикал компанийн хийсэн чичирхийлэл хэмжилтийн мэдээллийг худалдаж авах, эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний шинэ мэдээлэл олж авах - [redacted] ам. доллар

БҮГД ДҮН [redacted] ам. доллар

8. Чичирхийлэл хэмжилтийн тойм, эсвэл нарийвчилсан судалгааг хийх хоёрдахь жилийн ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд гэрээт талбайн судалгааны нарийвчилсан шинжилгээ, үнэлгээг бэлтгэх.

Б. Сургалт, дадлагажуулалт-Эхний жил

Медаллион компани нь гэрээт талбайд хийх эхний жилийн ажил үүргийн нэг хэсэг болгон МГТ компанийн нэг геологичийг англи хэл болон геологийн судалгааны ажил үүрэгт сургана. Медаллион компанийн хүлээх үүрэг нь МГТ компанийн геологичийг АНУ-д суралцах болон гэрээт талбайн хүрээнд хээрийн судалгаа хийх хугацаанд замын болон амьжиргааны зардлыг төлөх явдлаар хязгаарлагдана.

Медаллион компани нь эхний жилд гэрээт талбайд [redacted] ам доллараас илүү зардал гаргавал илүүдлийг хоёр дахь жил болон дараачийн жилүүдийн үүргээс хасч тооцно.

В. Ажил үүрэг-Хоёрдахь жил

Тооцоолсон өртөг: [redacted] ам. доллар

1. 1400 км чичирхийлэл хэмжилтийн тойм судалгаа хийнэ. Медаллион компанийн тавьж буй шаардлагын түвшинд ийм чичирхийлэл хэмжилтийн судалгааг хийж чадах нөхцөлд Медаллион компани энэхүү гэрээт судалгааг монголын чичирхийлэл хэмжилтийн ангиа хийлгэхийг эрмэлзэнэ.

2. Чичирхийлэл хэмжилтийн нарийвчилсан судалгаа хийх талбай тодорхойлохын тулд газрын гадаргуугийн болон гүнийн геологийг судалгааг ерөнхий чичирхийлэл хэмжилтийн шинэ мэдээлэлтэй нэгтгэн судална.

Сургалт, дадлагажуулалт-Хоёрдахь жил

1. Медаллион компани гэрээт талбайн хувьд хийх хоёрдугаар жилийн ажил үүргийн нэгэн хэсэг болгож, МГТ компанийн нэг геологичийг англи хэл болон геофизикийн ажилд сургана. Медаллион компанийн үүрэг нь МГТ компанийн геологичийг сургах явцад зам болон амьжиргааны зардлыг төлөх явдлаар хязгаарлагдана.

Медаллион компани нь чичирхийлэл хэмжилтийн судалгаа хийх мэдээлэл авах үйл ажиллагаанд монголын чичирхийлэл хэмжилтийн ангийг сургаж, олон улсын газрын тосны аж үйлдвэрт хүлээн зөвшөөрөхүйц мэргэжлийн түвшинд туршлагажуулна.

Медаллион компани нь хоёр дахь жилд гэрээт талбайд, эхний жилд илүү гүйцэтгэсэн ажлыг оролцуулаад [redacted] ам доллараар илүү зардал гаргавал, илүүдлийг гуравдахь жил болон дараачийн жилүүдийн ажлаас хасч тооцно.

Эхний үе шатны ажлын хуваарь болон гэрээний төсөв-Эхний болон хоёрдахь жил

Төсөв болон ажлын хуваарийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш гуч (30) өдрийн дотор гаргаж өгнө. Гэрээний хүчин төгөлдөр болон хугацаа нь түүнд гарын үсэг зурснаас хойш жар (60) дахь өдрөө эхэлнэ.

II үе шат. Гуравдахь болон дөрөвдөх жил

A. Ажил үүрэг-гуравдахь жил

Тооцоолсон өртөг: [redacted] доллар

500 км чичирхийлэл хэмжилтийн ерөнхий судалгаа хийнэ

Чичирхийлэл хэмжилтийн ерөнхий болон нарийвчилсан судалгааны гэрээт ажлыг хийхэд монголын ангийг ажиллуулахыг эрмэлзэн үзнэ.

Чичирхийлэл хэмжилтийн 500 км нарийвчилсан судалгаа хийнэ.

Хайгуулын эхний цооног ерөмдөх газрыг тодорхойлохын тулд геологийн зураглалыг чичирхийлэл хэмжилтийн шинэ мэдээлэлтэй нэгтгэн судлах ажлыг үргэлжлүүлнэ. Гэрээт талбайн гүнийн нэгтгэсэн шинжилгээг бэлтгэнэ.

Медаллион компани нь гуравдахь жилд цооног ерөмдөхөөр шийдвэл, уг цооногийг тухайн жилийн ажил үүрэгт багтсан гүйцэтгэнэ.

Медаллион компани нь гуравдахь жилд гэрээт талбайд түрүүчийн жилүүдэд илүү гүйцэтгэсэн ажлыг оролцуулаад [redacted] ам доллараас илүү зардал гаргавал илүүдлийг дөрөвдөх болон дараачийн жилүүдийн ажлаас хасч тооцно.

Б. Ажил үүрэг-дөрөвдөх жил

Тооцоолсон өртөг: [redacted] доллар

1. Чичирхийлэл хэмжилтийн 500 км нарийвчилсан судалгаа хийнэ.

2. Эхний цооногийн байршлыг тодорхойлохын тулд геологийн зураглал болон чичирхийлэл хэмжилтийн шинэ мэдээллийг нэгтгэн судална.

Медаллион компани нь дөрөвдөх жилд гэрээт талбайд [redacted] ам.доллараас илүү зардал гаргавал илүүдлийг тавдахь болон дараачийн жилүүдийн ажлаас хасч тооцно.

В. Сургалт, дадлагажуулалт-гуравдахь ба дөрөвдөх жил

Медаллион компани гуравдахь жилийн ажил үүргийн нэг хэсэг болгож, МГТ компанийн ерөмдлөгийн нэг инженерийг англи хэл болон ерөмдлөгийн инженерийн ажилд сургана. Дөрөвдөх жилийн ажил үүргийн нэг хэсэг болгож, Медаллион компани нь МГТ компанийн газрын тосны инженерийг англи хэл болон газрын тосны инженерийн ажилд сургана. Медаллион компанийн үүрэг нь МГТ компанийн хүмүүсийг АНУ-д болон гэрээт талбайд цооног ерөмдөх үед ажил дээр нь сургах явцад замын болон амьжиргааны зардлыг төлөх явдлаар хязгаарлагдана.

Медаллион компани нь гуравдахь болон дөрөвдөх жилд энэ

жилүүдэд шаардлагатай МГТ компанийн ажилтнуудыг нэмж сур
нэмж сургасан ажилтнуудын тоог тавдахь болон дараачийн жи
үүрэгт оруулан тооцно.

Ш үе шат. Тавдахь жил

А. Ажил үүрэг-тавдахь жил

Тооцоолсон өртөг: [redacted] ам. доллар

1. Чичирхийлэл хэмжилтийн 500 км нарийвчилсан судалгаа
2. Цооногийн байршлыг тодорхойлохын тулд гуравдахь
өрөмдсөн цооногийн мэдээллийг чичирхийлэл хэмжилтийн
мэдээлэлтэй нэгтгэн судална.

3. Хайгуулын нэг цооног өрөмдөнө.

Медаллион компани нь гуравдахь жилд өрөмдөх цооногоос
тавдахь жилээс өмнө өөр цооног өрөмдсөн бол түүнийг т
жилийн өрөмдлөгийн ажил үүрэгт тооцно.

Медаллион компани нь тавдахь жилд [redacted] ам. дол
илүү зардал гаргасан бол илүүдлийг хайгуулын хугацааг су
тохиолдолд дараачийн жилүүдийн ажил үүргээс хасч тооцно.

Б. Сургалт дадлагажуулалт-тавдахь жил

Медаллион компани нь тавдахь жилийн ажил үүргийн нэг
болгож, МГТ компанийн нэг эдийн засагчийг англи хэл,
засагчийн ажилд сургана. Медаллион компанийн үүрэг
компанийн эдийн засагчийн суралцах хугацаанд замын
амьжиргааны зардлыг төлөх явдлаар хязгаарлагдана.

Үндсэн хугацаанд талбайг буцааж өгөх.

Техникийн шинжилгээнээс үзэхэд эхний үе шатыг үргэлж
хоёрдахь үе шатанд орох баталгаа байхгүй гэж гэрээлэгч
цаашид үүрэг хүлээхгүйгээр гэрээт талбайг бүхэлд нь
өгнө. Түүнчлэн гэрээлэгчийн үзэж байгаагаар үр дүн нь хоёрдахь
шатыг үргэлжлүүлж, гуравдахь үе шатанд орох баталгаа болохыг
гэрээлэгч цаашид үүрэг хүлээхгүйгээр гэрээт талбайг бүх
буцааж өгнө. Аливаа тохиолдолд гэрээлэгч нь гэрээт талбайн
таван (25) хувийг, хайгуулын үндсэн хугацаа дууссан, эсвэл
хугацааг сунгасан хугацаа дууссан эцсийн өдрөөс хойш гуч

хоногийн дотор буцааж өгнө.

6.2. Өрөмдөх аргууд

Гэрээлэгч нь 6.1-ийн дагуу өрөмдөх хайгуулын аливаа цооногийг олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргаар өрөмдөх бөгөөд дараах нөхцөлүүдийн аль нэг нь түрүүлж тохиолдох явдалд цооногийг өрөмдсөнд тооцно. Үүнд:

1. цооног нь төслийн гүнд хүрсэн,
2. цооног нь нээлтийн цооног болсон,
3. цооног нь суурь чулуулагт хүрсэн,
4. цооног нь үл нэвтрэх биетэд, геологийн хэт халуун градиентэд хүрсэн бол дээр дурдсанчлан газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлалын дагуу өрөмдлөгийг зогсоох нь зүйтэй гэж үзсэн зэрэг болно.

6.3. Давуулан гүйцэтгэсэн ажлыг шилжүүлэн тооцох тухай

Хэрэв Гэрээлэгч нь гэрээт жилийн аль нэгэнд 6.1-д заасан наад захын ажил үүргээ давуулан гүйцэтгэсэн бол түүнийг дараачийн гэрээт жилд гүйцэтгэх ажил үүрэгт шилжүүлэн тооцож болно. Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө гэрээлэгчийн гүйцэтгэсэн хайгуулын аливаа үйл ажиллагааг хайгуулын эхний гэрээт жилд гүйцэтгэсэнд тооцно.

6.4. Хайгуулын ажлын хөтөлбөр ба төсөв

Гэрээлэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор үүний дараа хайгуулын үе шат бүрийн жил эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө тухайн жилд хийхээр санал болгож буй хайгуулын үйл ажиллагааг тусгасан гэрээт талбайд гүйцэтгэх ажлын хөтөлбөр ба төсвийг боловсруулж, Засгийн газрын төлөөлөгчид өгнө. Тухайн жил эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө Гэрээлэгч, Засгийн газрын төлөөлөгч хоёр хайгуулын ажлын хөтөлбөр ба төсвийг хянаж хэлэлцэхээр уулзаж ярилцана. Хэрэв үүний дараа гэрээлэгч нь ажлын хөтөлбөр, төсвөө дахин өөрчлөх аваас хийсэн өөрчлөлтийнхөө хуулбарыг Засгийн газрын төлөөлөгчид даруй өгнө. Хэрэв дээрх өөрчлөлт нь өмнөх хувилбараас ихээхэн зөрөөтэй нөхцөлд уг

өөрчлөлтийн тухай мэдээлэл авсны дараа ажлын 15 өдрийн дотор гэрээлэгч ба Засгийн газрын төлөөлөгчийн хэн нэг нь уулзах хүсэлт гаргавал тэр өөрчлөлтийг хянаж хэлэлцэхээр гэрээлэгч ба Засгийн газрын төлөөлөгч дахин уулзаж ярилцана.

ДОЛООДУГААР ЗҮЙЛ
ТАЛБАЙ БУЦААЖ ӨГӨХ

7.1. Үнэлгээний талбай ба үр ашигтай нээлт

Энэ 7 дугаар зүйлд заасантай үл нийцэх аливаа бусад зүйлийг үл харгалзан гэрээлэгч нь үнэлгээний талбай, эсвэл үр ашигтай нээлт бүхий талбайг бүхлээр нь буюу аль нэг хэсгийг нь буцааж өгөх үүрэг хүлээхгүй.

7.2. Гэрээ ёсоор талбайг буцааж өгөх

Гэрээлэгч нь:

а. хайгуулын эхний үе шат дуусахад эсвэл дуусахаас өмнө анхдагч гэрээт талбайн 25-аас доошгүй хувийг,

б. хайгуулын хоёрдугаар шат дуусахад эсвэл дуусахаас өмнө анхдагч гэрээт талбайн мөн 25-аас доошгүй хувийг,

в. хайгуулын хугацаа дуусахад үр ашигтай нээлт, үнэлгээний талбайнаас бусад бүх хэсгийг тус тус буцааж өгсөн байна.

г. гэрээлэгч нь гэрээт талбайн аль ч хэсгийг буцааж өгөхдөө түүний гадаргуугийн унаган төрхийг сэргээсэн байна.

7.3. Өөрийн хүсэлтээр буцааж өгөх

6.1-ийн а-д дурдсанаар сайн дураараа буцааж өгөх талбайгаас гадна гэрээлэгч нь гэрээт талбайг бүгдийг эсвэл аль нэг хэсгийг, эсвэл хэд хэдэн хэсгийг сайн дураараа буцаан өгч болно. Ийнхүү сайн дураараа буцааж өгсөн хэсгүүдийг дээрх 7.2-т дурдсан гэрээ ёсоор буцааж өгсөн талбайд оруулан тооцно.

Гэрээлэгч нь энэхүү ҮП зүйлийн дагуу буцааж өгсөн гэрээт талбайн аль ч хэсэгт цаашид үүрэг хүлээхгүй. Гэхдээ гэрээлэгч нь энэхүү гэрээний 6.1-д зааснаар хүлээсэн наад захын ажил үүргээсээ

татгалзах зорилгоор талбайг сайн дураараа буцаах өсгүй.

Гэрээлэгч аль ч гэрээт жил тухайн жилийн ажлын хөтөлбөрийн төсвийг МГТ компанид өгөх бөгөөд хэрэв гэрээлэгч төсөвт заасан ажлыг бүрэн хийж дуусахаас өмнө гэрээт талбайг бүхэлд нь буцаан өгөх тохиолдолд тухайн жилд зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгээгүй ажилд ногдох хөрөнгийг талбайг буцаан өгсөн өдрөөс хойш зургаан (6) сарын дотор МГТ компанид шилжүүлнэ.

НАИМДУГААР ЗҮЙЛ ТӨЛБӨР БА БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

8.1. Төлбөр (роялти)

Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг МГТ компани Монголын Засгийн газарт төлнө.

8.2. Өртөгт тос

а. гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад гарсан өртөг зардлыг нөхөж авах зорилгоор энэхүү 8.2-ын дагуу хуанлийн сар тутам гэрээт түүхий тос (өртөгт тос)-ны хувийг авч зарцуулах эрхтэй. Хуанлийн аль ч сард гэрээлэгчийн авч ашиглах эрхтэй өртөгт тосны хувь нь энэхүү 8.2-д заасны дагуу тухайн үед нөхөж аваагүй гэрээлэгчийн нийт зардалтай үнэ өртгийн хувьд тэнцэх гэрээт түүхий тосны хэмжээтэй адил байна. Гэхдээ гэрээлэгч нь хуанлийн сар бүрийн гэрээт бүх түүхий тосны нийт хэмжээний хувиас илүү өртөгт тос авах эрхгүй. Түүнчлэн гэрээлэгчийн нөхөж аваагүй үлдсэн бүх өртөг зардал нь дараа дараагийн хуанлийн саруудад бүрэн нөхөж дуустал шилжин тооцогдож байна.

б. гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааны бүх өртөг, зардлыг хайгуулын зардал, урсгал зардал ба ашиглалтын зардал гэж давхардуулахгүйгээр ангилна. Эдгээр өртөг зардал нь 8.2-ын дагуу дараах дарааллаар нөхөгдөнө. Үүнд: 1. хайгуулын зардал, 2. урсгал зардал, 3. ашиглалтын зардал. Тодруулга хийхэд, ашиглалтын зардал нь хайгуулын үед, хайгуулын зардал нь

ашиглалтын үед гарч болно гэдгийг харилцан ойлгож зөвшөөрөлцөв.

в. 10.1 болон 10.2-ын дагуу Монголын Засгийн газарт төлсөн урамшууллыг өмнөх заалтыг эс харгалзан нөхөн төлөхгүй.

8.3. Ашигт тос

а. хуанлийн сард ногдох өртөгт тосны нийт хэмжээг хасаад үлдсэн бүх гэрээт түүхий тос (хуваах тос)-ыг МГТ компани болон гэрээлэгчийн хооронд тухайн хуанлийн сард гаргасан хуваах тосны өдрийн дундаж хэмжээнд тулгуурлан дор заасан харьцаагаар хуваана. Үүнд:

1. Хуанлийн сарын хуваах тосны өдрийн дундаж хэмжээ нь 50000 баррелиас бага байвал:

Монголын Засгийн газарт [] хувь, гэрээлэгчид [] хувь нь ногдоно.

2. Хуанлийн сарын хуваах тосны өдрийн дундаж хэмжээ нь 50001 баррелиас 100000 хүртэл баррель хүрсэн байвал, :

Монголын Засгийн газарт [] хувь, гэрээлэгчид [] хувь нь ногдоно.

3. Хуанлийн сарын хуваах тосны өдрийн дундаж хэмжээ нь 100001 баррелиас их байвал:

Монголын Засгийн газарт [] хувь, гэрээлэгчид [] хувь нь ногдоно.

б. Хайгуул олборлолтонд зориулсан гэрээлэгчийн өртөг, зардал өртөгт тосоор бүрэн нөхөн төлсний дараа нийт тосноос өртөг тосонд зориулагдаж байгаа [] хувийг Монголын Засгийн газарт [] хувь, гэрээлэгчид [] хувь ногдохоор хуваах бөгөөд нийт гаргасан тосны үлдсэн хэсэг болох [] хувийг 8.3. а-д заасны дагуу хуваана.

в. 8.3. а-ийн 1, 2, 3 болон 8.3. б-д дурдсан хуваах тосны үйлдвэрлэлийн өсөлтийг хуанлийн сарын өдрийн дундаж хэмжээнд харьцуулж хуваана.

Өдрийн дундаж хэмжээг тооцоолохдоо тухайн хуанлийн сард жинхэнэ үйлдвэрлэсэн болон хуримтлуулсан хуваах тосны нийт хэмжээг түүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан нийт өдрийн тоонд хуваа

замаар гаргана.

8.4. Өртөгт тосны үнэлгээ

а. Энэхүү гэрээнд өртөгт тосны үнэ нь Монгол улсын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 16.1-д болон энэхүү гэрээний 8.4-д зааснаар тодорхойлогдоно.

б. Бүх өртөгт тосыг үнэлэхдээ, өмнөх хуанлийн улиралд дэлхийн зах зээл дээр чөлөөт валютаар ижил чанарын түүхий тосыг шууд худалдан борлуулсан үнийн (тухайн зах зээлийн онцлог, газрын тосны чанар зэрэг бусад физик шинжийг зааж өгнө) жигнэсэн дундажийг хэрэглэнэ. Гэхдээ зэрэг, чанараараа ялгаатай газрын тосыг өөр өөр үнээр худалдсан бол гэрээлэгчийн борлуулсан экспортын үнийн жигнэсэн дундажийг, зэрэг, чанар тус бүрээр нь ялган үнэлсэн үнийг хэрэглэн тодорхойлж болно.

в. 8.3-д заасан "экспортын үнэ" гэдэг нь бараагаар солилцох, газар дээр нь борлуулалт хийх зэрэг төсөөтэй бусад хэлбэрийг үл оролцуулан, хувь нийлүүлэгч биш этгээд экспортын цэг дээр чөлөөт валютаар худалдсан, эсвэл өөрөөр тохиролцон борлуулсан цэвэр үнийг хэлнэ.

Комисс болон худалдаа хийлгэсний шагналыг тэр хэмжээ ий тосыг олон улсын газрын тосны аж үйлдвэрт харилцан бие даасан талуудын хооронд худалдахад хэрэглэгдэж байгаа ердийн хэмжээнээс хэтрэхгүй байхаар тогтооно.

8.5. Үйлдвэрлэлийн урьдчилсан тооцоо

Анхны үр ашигтай үйлдвэрлэл эхэлснээс хойш хуанлийн хагас жил эхэлснээс ер (90)-ээс доошгүй хоногийн дотор гэрээлэгч нь үр ашигтай нээлт бүрийн хувьд олон улсын газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн нийтлэг аргын дагуу олборлож борлуулах түүхий тосны хэмжээг хамгийн дээд хэмжээгээр бодож гаргасан урьдчилсан тооцоог бусад холбогдох хүчин зүйлийн хамт Монголын Засгийн газарт танилцуулна.

20
11

8.6. Дуталт ба хэтрүүлэлт

Аль нэг тал авах ёстой гэрээт түүхий тосоо зарим үед бүр хэмжээгээр нь аваагүй байж болохыг хүлээн зөвшөөрч байна. (Энэ тохиолдолд түүнийг дутуу авагч гэнэ). Энэ тохиолдолд нөгөө талынх нь хувьд үйлдвэрлэл бүрэн хэмжээгээр үргэлжилж (энэ тал хэтрүүлэн авагч гэнэ) болох бөгөөд хэтрүүлэн авагчтай тэнцэл болгох зорилгоор дутуу авагчийн нөхөн авч болох гэрээт түүхий тосны хэмжээг гэрээлэгч тооцон бүртгэнэ. Тэнцлийг аль болгомог богино хугацаанд тогтоохын тулд дутуу авагчид нэмэлт гэрээт түүхий тосыг нөхөж өгнө. Гэхдээ ийм хуваарилалтыг үйлдвэрлэл хэвийн үйл ажиллагаа, борлуулалтад саад учруулахгүй байх арга замаар хийж гүйцэтгэнэ.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ ХИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ

9.1. Хийн зах зээл

Нээлтийн цооног буюу хий олборлох бололцоотой үр ашигтай нээлт шинээр олдвол (түүхий тостой хамт эсвэл өөр байдлаар) хийг олборлох, борлуулах төслийг хэрэгжүүлэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай гэж үзэх нэг буюу хэд хэдэн зах зээл Монгол улсад, эсвэл хилийн чанадад байгаа эсэхийг тогтоох зорилгоор нэг талынхаа хүсэлтээр Засгийн газрын төлөөлөгч, гэрээлэгч хий уулзана. (Байгааг нь тогтоосон зах зээлийг цаашид "хийн үр ашигтай зах зээл" гэнэ).

Хэрэв Засгийн газрын төлөөлөгч болон гэрээлэгч нь хийн үр ашигтай нэг буюу хэд хэдэн зах зээл тодорхойлж чадаагүй буюу 9.1-д заасан борлуулалтын харилцан хүлээж авч болохуйц тохиролцоо анх хүрч чадаагүй бөгөөд өөрөөр тохиролцоогүй бол энэ асуудлыг улиралд нэгээс цөөнгүй удаа уулзаж байна.

9.2. Хийн борлуулалт ба бүтээгдэхүүн хуваалт

Засгийн газрын төлөөлөгч ба гэрээлэгч нь хийн үр ашигтай буюу хэд хэдэн зах зээл байна гэж үзвэл борлуулалтын харилцан хүлээн авч болохуйц тохиролцоонд хүрэхийг хичээж байна. Тохиролцоо

аль ч тохиолдолд гэрээлэгч нь энэ гэрээнд заасны дагуу гэрээт түүхий тос авахын адилаар гэрээт хийг авч ашиглах эрхтэй бөгөөд харин өртөг нөхөх зорилгоор гэрээлэгчийн авах гэрээт хийн хувь нь [redacted] хүртэл хувь байх бөгөөд гэрээт хийн үлдсэн хэсгийг Монгол улс, гэрээлэгч хоёр бүх гэрээт талбайн хувьд тавь, тавин хувиар тус тус хувааж авна.

9.3. Хийн тэнцлийн тухай хэлэлцээр

Аль нэг тал гэрээт талбайгаас өөрт ногдох гэрээт хийг бүрэн хэмжээгээр аваагүй аливаа тохиолдолд тооцоог балансжуулж байх зорилгоор хийг тэнцэтгэх тухай хэлэлцээрийг талууд байгуулна. Энэ хэлэлцээр нь 8.6-д заасан дуталт, хэтрүүлэлтийн тухай заалтад нийцсэн байна.

9.4. Үнэлгээний ба олборлолтын төлөвлөгөө

Тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламжийн их хэмжээний хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хангахад борлуулах төслийг үнэлэх, боловсруулж хэрэгжүүлэх нь урт хугацааны зах зээл, гэрээ хэлэлцээр шаардана гэдгийг талууд хүлээн зөвшөөрч байна. Иймд талууд тухайн хийн олборлолтын хугацаа нэг бүрийг дээрх удаан хугацааны шаардлагаас үндэслэн харилцан тохиролцоо сунгана.

Цаашилбал, энэ гэрээний 5.3 (б), 5.4 (б)-г үл харгалзан нэг болон хэд хэдэн агууламжид байгаа хий, түүнийг тооцоолсны үндсэн дээр (түүхий газрын тосны тооцоолсон нөөцийг үл харгалзан) нээлтийг нээлтийн цооног буюу үр ашигтай нээлт гэж тодорхойлсон бол гэрээлэгч нь 9.2-т заасан борлуулалтын тохиролцоонд хүрэхээс нааш үнэлгээний хөтөлбөр буюу ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй бөгөөд хайгуул, эсвэл ашиглалтын хугацааг тухайн нээлтийн цооног, эсвэл үр ашигтай нээлтийг бүртгэсэн өдрөөс эхлээд тэрхүү борлуулалтын тохиролцоонд хүрсэн өдөр хүртэл үргэлжлэх хугацаатай тэнцэх хугацаагаар сунгана.

АРАВДУГААР ЗҮИЛ
УРАМШУУЛАЛ, ТАТВАР, ГАЗРЫН ТҮРЭЭС БА
ЗАХИРГААНЫ ШИМТГЭЛ

10.1. Урамшуулал

а. Гарын үсэг зурсны урамшуулал

Монгол улсын Засгийн газар уг гэрээг баталмагц гэрээлэгч саналын төлбөр болгон [redacted] ам. долларыг МГТ компанид төлнө.

б. Үйлдвэрлэлийн урамшуулал

30 хоног дараалан өдөрт [redacted] -аас дээш баррель газрын т олборлосны дараа [redacted] ам. доллар төлнө.

10.2. Урамшуулал өгөх бусад тохиолдол

Гэрээлэгч нь 6.1 дүгээр зүйлийн дагуу МГТ компани мэргэжилтнүүдийг сургана.

10.3. Урамшуулал төлөх

а. 10.1-д заасан бүх урамшууллыг тухайн урамшууллыг зориул эрхийг үүсгэх үйл явдал буюу тодорхой өдрөөс хойш 60 хоног дотор АНУ-ын доллараар төлнө.

б. 10.2-д заасан бусад урамшууллыг АНУ-ын доллараар буюу М компани ба гэрээлэгчийн хооронд тохиролцсоны дагуу төлнө.

10.4. Орлогын татвар

а. Гэрээлэгч болон түүнтэй адилтгах татвар төлөгчид хамаар Монгол улсын Засгийн газрын Орлогын татварын хууль тогтоомж дагуу төлбөл зохих аливаа хэмжээний татвар, төлбөрийг тооцон төлөхийн тулд гэрээлэгч нь 10.4 (б)-д заасны дагуу татв ногдуулах орлогын хувиар тооцсон татварыг төлөөлүүлэн (орлог орлон төлөгдөх татвар) төлнө. Гэрээлэгч нь нийт орлого бол орлогын орлон төлөгдөх татварыг төлсөн тухай жил бүр тайм гаргаж, Монгол улсын татварын холбогдох байгууллагууд танилцуулна. Орлогын татварыг ажлын хөтөлбөрийн дагуу хуанли улирал бүрийн эцсийн сарын сүүлчийн арван хоногийн дотор тө жилийн эцсийн тооцоог дараа оны нэгдүгээр сард багтаан монгол

татварын байгууллагатай хийж байна.

6.10.4-ийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор гэрээлэгчийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны татвар ногдуулбал зохих жилийн орлогыг (татвар ногдуулах орлого) дараах байдлаар тооцоолно. Үүнд:

1. Энэ гэрээ ёсоор гэрээлэгчийн хуваарьт гэрээт түүхий тос ба гэрээт хийг худалдаж, эсвэл бусад хэлбэрээр борлуулж олсон гэрээлэгчийн орлогын нийт дүнгээс: 1.1. энэ гэрээний ҮШ ба 1Х-ийн дагуу тухайн жилд өртөгт тос ба өртөгт хийгээр нөхөх зардал болон, 1.2. энэ гэрээний 8.1, 10.1(б) ба 10.2 (урьдчилсан орлого)-т заасны дагуу МГТ компанид тухайн жилд төлсөн төлбөрийг тус тус хасч,

2. Хавсралт Е-ын татварыг хэрэгжүүлэх тухай заалтад тусгасан хэлбэрээр орлон төлөгдөх татварт ногдох орлогоор тодорхойлогдох нийт үнэтэй тэнцэх хэмжээг нэмж тооцно.

Хуанлийн нэг жилийн хугацаанд гэрээлэгч өртөгт тосны болон хийн орлогоор нөхөн төлөх ёстой өртөг, зардлын хэмжээ болон 10.1, 10.2-ын дагуу хийгдсэн төлбөр нь гэрээлэгчээс өөрт ногдох гэрээт түүхий газрын тос болон гэрээт хийг худалдаж, эсвэл бусад хэлбэрээр борлуулж, олсон орлогын нийт хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд уг хийгдсэн төлбөр, өртөг, зарлагаас хэтэрсэн хэмжээгээр удаах хуанлийн жил болон дараа дараагийн жилүүдийн төлбөрөөс чөлөөлж, уг алдагдал бүрэн нөхөгдөх хүртэл хойшлуулан суутгаж тооцно.

а. МГТ компани нь гэрээлэгчийн татвар ногдох орлогод ногдуулсан гэрээлэгчийн орлон төлөх татварыг гэрээлэгчийн өмнөөс төлөх үүрэг хүлээж, тийнхүү төлж барагдуулна. Гэрээлэгчийн өмнөөс МГТ компанийн төлсөн орлон төлөх татварыг энэхүү 10.4 болон хавсралт Е-ийн дагуу газрын тосны үйл ажиллагаанаас гэрээлэгчийн олсон орлого гэж үзнэ.

б. Монгол улсын Засгийн газар хуанлийн нэг жил дууссан өдрөөс 150 хоногийн дотор тухайн жилийн гэрээлэгчийн орлон төлөх татварыг хураан авсан тухай баримтыг гэрээлэгчид олгоно. Энэхүү баримт нь татварын зохих ёсны байгууллагаас олгогдсон байх бөгөөд

татварын хэмжээ болон ийм баримтад шаардагдах бусад зүйлийг тусгасан байна.

в. Энэхүү Х зүйлийн дагуу татвар төлөхөд гэрээлэгч нь хуулийн нэгээс дээш тооны этгээдээс бүрдсэн байвал "Гэрээлэгч" гэдэг нь хуулийн этгээд тус бүрийг гэрээлэгч гэсэн утгыг илэрхийлнэ.

г. Гэрээлэгч нь (түүний дотор хувь нийлүүлэгчид болон хувь эзэмшигчид, туншууд болон бусад хүү эзэмшигчид) энэ гэрээ хууль төгөлдөр байх хугацаанд 10.2-т заасан урамшуулал, энэхүү 10.2-т заасан орлон төлөх орлогын татвар, Засгийн газрын байгууллагуудаас жинхэнэ үзүүлсэн үйлчилгээний ердийн хөлс төлөх бөгөөд харин орлогын татвар болон бусад бүх татвар төлөх чөлөөлөгдөнө.

д. MGT компани гэрээлэгчийн өмнөөс төлсөн буюу 10.4 (а) зааснаар гэрээлэгч төлбөрөөс чөлөөлөгдөх ёстой орлогын татвар, төлөх татвар, орлогын татвар, бусад татвар төлөхийг Засгийн газрын аль нэг байгууллага, гэрээлэгчээс шаардвал гэрээлэгч Засгийн газрын төлөөлөгчтэй нэн даруй зөвлөлдөж, энэ шаардлагыг хэрхэх талаар Засгийн газрын төлөөлөгчийн заавар дагана. Энэхүү төлбөрийг гэрээлэгч заавал төлөх ёстой гэж үзвэл гэрээлэгчээс түүнийг төлсөн баримтыг авчирмагц Монгол Улсын Засгийн газар нехэн төлбөр хийнэ.

е. Гэрээлэгчийн гадаадын оролцон гүйцэтгэгч нь тэдгээрийн газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд ногдуулах, орлон төлөх орлогын татвар, орлогын татвар буюу бусад татвараас чөлөөлөгдөнө.

ж. Гэрээлэгчийн болон оролцон гүйцэтгэгчийн гадаадын ажиллагсад нь Монгол улсын Засгийн газар, тухайлбал, түүнийг нэг улс төрийн байгууллагаас ногдуулах орлогын бүх татвар нийгмийн даатгалаас чөлөөлөгдөнө.

з. Энэхүү 10.4-т заасан талуудын эрх, үүрэг нь тэдгээрийг дуусгавар болох хүртэл хүчинтэй байна.

10.5. Газрын түрээс

а. Гэрээлэгч нь Монгол улсын Засгийн газрын эзэмшилд байгаа газар дээр газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахдаа гэрээнд тусгайлан заасан эрхийг эдэлнэ.

б. Гэрээлэгч нь гэрээт талбайн хүрээнд байгаа талбайн хувьд газрын түрээсийг 1991 оны 7 дугаар сарын 5-нд хүчин төгөлдөр болсон "Монгол улсын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам"-ын хавсралт 3-ын дагуу газрын түрээс төлнө.

Гэрээлэгч нь анхны гэрээт жилийн газрын түрээсийг анхны гэрээт жилийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор болон дараа дараачийн жил эхэлснээс хойш 30 хоногийн дотор тус тус төлнө.

10. 6. Захиргааны шимтгэл

Гэрээлэгч нь МГТ компанид захиргааны үйлчилгээнд дараах шимтгэл төлнө. Үүнд:

америк доллар

1. Гэрээт талбайн захиалга бүрт
2. Хайгуулын хугацааг сунгах бүрт
3. Олборлолтын талбайн захиалгыг хүлээж авсан тухай мэдэгдэл бүрд
4. Олборлолтын гэрээт талбайг солих эсвэл өөрчлөлт оруулах бүрд
5. Олборлолтын хугацааг сунгах бүрд
6. Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны аль нэг эрхээ шилжүүлэх хүсэлт тавих бүрд

Гэрээлэгч нь 10. 6. 1-д заасан шимтгэлийг энэ гэрээг батлагдмагц МГТ компанийн өгсөн хаягаар чекээр төлнө. 10. 6. 2, 10. 6. 3, 10. 6. 4, 10. 6. 5 болон 10. 6. 6-д заасан төлбөрийг Монголын Засгийн газраар батлагдсаны дараа төлнө.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ХЭМЖИЛТ

11. 1. Бүтээгдэхүүн хуваах хэмжилт

а. Гэрээнд оролцогч талуудын хооронд хуваах гэрээт түүхий тос, гэрээт хийн хэмжээг тодорхойлох зорилгоор хэмжилт хийхдээ (Бүтээгдэхүүн хуваах хэмжилт) олон улсын газрын тосны үйлдвэрлэлд

хэвшсэн нийтлэг аргачлалыг хэрэглэнэ. Гэвч бусад (ганцаарчилсан цооногийн олборлолтын хэмжээг шалгах ба тогтоох) зорилгоор хийж болох хэмжилт нь бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн жишигтэй заавал нийцэх ёсгүй гэдгийг харилцан тохиролцов. Бүтээгдэхүүн хуваах хэмжилт нь гэрээний дагуу гэрээт түүхий тос, гэрээт хийн хэмжээг тодорхойлох, эдгээрийг талуудын хооронд хуваах ажлыг хянах үүрэгтэй бөгөөд еер зорилгоор хийсэн хэмжилтээс зөрөөтэй байж болно.

б. Энэхүү бүтээгдэхүүн хуваах хэмжилтийг экспортын тос дамжуулах хоолойн систем, эсвэл 8 ба 9 дүгээр зүйлийн дагуу гэрээлэгчээс газрын тос түгээх бусад байгууламжийн төгсгөлийн гаралтын холбоос буюу холбооснуудад, эсвэл зарим тохиолдолд тохиромжтой байж болох еер цэг буюу цэгүүд дээр хийнэ. Хэрэв гэрээт түүхий тос буюу гэрээт хий нь аль нэг зорилгоор хэд хэдэн цооног буюу нээлтэнд хамрагдаж байвал, гэрээлэгч нь тухайн хуваарилалтыг олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлалаар хийнэ.

в. Энэхүү 11 дүгээр зүйлд заасан бүтээгдэхүүн хуваах хэмжилт хийхээс өмнө гэрээлэгч, монголын Засгийн газар хоёрын аль нь ч еерт ногдох гэрээт түүхий тос ба гэрээт хийг авч ашиглах эрхгүй гэдгийг харилцан ойлголцож зөвшөөрөлцөв. Гэхдээ Монгол улсын дотоод хэрэгцээг хангах зорилгоор хуваарьт гэрээт түүхий тос ба гэрээт хийгээ авч ашиглах Монгол улсын Засгийн газрын эрхийг үүгээр хязгаарлахгүй.

11.2. Хэмжилтийг залруулах

а. Хэрэв гэрээлэгч нь бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн аль нэг багаж хэрэгсэлд тохируулга хийх, засварлах, эсвэл солихыг хүсвэл Засгийн газрын төлөөлөгчид зохих мэдэгдэл өгөх ба Засгийн газрын төлөөлөгчид тухайн үйл ажиллагааг хянах боломж олгоно.

б. Засгийн газрын төлөөлөгч нь бүтээгдэхүүн хуваах аль ч хэмжилтийг ямар ч үед ажиглах, хэмжилтийн нарийвчлалыг тодорхойлох зорилгоор шалгах эрхтэй. Хэрэв хэмжилт нь олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг аргачлалын дагуу хийгдэхгүй байгаа нь ийм шалгалтаар илэрвэл Засгийн газрын төлөөлөгч нь түүнийг залруулах арга хэмжээ авахыг гэрээлэгчээс

хүс
хой
эхэ
төл
гар
11.

хэм
хад
шаа

12.

тух
хэв
хай
хяз
Гэр
газ

12.

тух
газ
тан

12.

хуу
зор
сөр

хүсч болно. Хэрэв гэрээлэгч энэ хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор засах арга хэмжээ авч эхлэхгүй болон эхэлсэн ч уг засах ажиллагааг удаан үргэлжлүүлбэл Засгийн газрын төлөөлөгч нь засуулах арга хэмжээ авч зардлыг гэрээлэгчээр гаргуулна.

11.3. Хэмжилтийн бүртгэл

Гэрээлэгч нь бүтээгдэхүүн хуваах хэмжилтийн бүртгэлийг хэмжилт хийсэн өдрөөс хойш наад зах нь 2 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд Засгийн газрын төлөөлөгч нь эдгээртэй шаардлагатай гэж үзсэн ямар ч үед танилцана.

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ
ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЭЛ

12.1. Техникийн ерөнхий бүртгэл

Гэрээлэгч нь өөрийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тухай техникийн бүртгэлийг олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг горимын дагуу хөтлөх бөгөөд энэ нь зөвхөн хайгуул, ашиглалт, олборлолт болон нэрэх ажиллагаагаар хязгаарлагдахгүй. Эдгээр бүртгэлийг англи хэл дээр хөтөлнө. Гэрээлэгч нь энэ бүх баримт бичиг, тайлангийн хувийг Засгийн газрын төлөөлөгчийн хүсэлтээр сар, улирал, жилээр гаргаж өгнө.

12.2. Геофизикийн мэдээлэл

Гэрээлэгч нь геофизикийн үндсэн мэдээллийг Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу гаргаж өгнө. Засгийн газрын төлөөлөгч нь эдгээр эх мэдээллийг шаардлагатай үед шалгаж, танилцах боломжтой байна.

12.3. Геологи, петрофизик болон үйлдвэрлэлийн сорилтын мэдээлэл

Гэрээлэгчийн гаргаж өгөх мэдээллийг Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журамд заасан байна. Сорилт, үнэлгээ хийх зорилгоор гэрээлэгч нь керн, шлам, чулуулаг болон газрын тосны сорьц дээжийг авч монголоос гаргах эрхтэй. Хэрэв Засгийн газрын

Handwritten initials/signature

Г
н
а
г
эг
эл
ын
ч
ыг
сын
гуу
рын
ээс

төлөөлөгч нь эдгээр дээжийг буцааж авах хүсэлтээ гаргаснаас хойш 1 жилийн дотор тэдгээрийг шаардахгүй бол гэрээлэгч нь уг дээжийг өөрийн үзэмжээр ашиглана. Хэрэв гэрээлэгч нь цооногт сорилт хийхээр төлөвлөвөл Засгийн газрын төлөөлөгчид сорилт хийхээр төлөвлөсөн өдрөө мэдэгдэх ба хэрэв Засгийн газрын төлөөлөгч хүсвэл, түүнд энэ сорилтыг газар дээр нь очиж хянах боломжийг олгоно.

12.4. Тайлал хийсэн мэдээлэл, газрын тос ба хийн нөөцийн тайлангууд

Гэрээлэгчээс Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгөх тайлал хийсэн мэдээлэл, тайланг МГТ компанийн баталсан Газрын тосны дүрэмд заасан байна.

12.5. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

Гэрээлэгч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй цэг бүрээс олборлосон тос, хийн хэмжээг үзүүлсэн бүртгэлийг хөтлөх ба мэдээлэл, тайланг МГТ компанийн баталсан Газрын тосны дүрэмд заасны дагуу Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгнө.

12.6. Хамтарсан хороо

Энэ гэрээний дагуу анхны үр ашигтай нээлтээс үр ашигтай үйлдвэрлэл явуулж эхэлсэн мөчөөс гэрээлэгч болон Засгийн газрын төлөөлөгч нь үйлдвэрлэл явуулж байгаа бүх агууламжийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, мэдээллийг судлах болон Засгийн газрын төлөөлөгч, гэрээлэгчийн хооронд захиргааны холбогдолтой асуудлуудыг зохицуулах зорилгоор хамтарсан хороо байгуулна.

12.7. Бусад ашигт малтмал

Гэрээлэгч нь гэрээт талбайд явуулж буй газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад газрын тостой холбоогүй ашигт малтмалын үр ашигтай байж болохуйц нөөцийг нээвэл энэ тухай Засгийн газрын төлөөлөгчид даруй мэдэгдэнэ. Эдгээр ашигт малтмал нь Монгол улсын өмч байна.

12. 8. Нууцлал

Талууд нь энэхүү 12.8-д заасныг оролцуулахгүйгээр ХП зүйлд дурдсан бүх тайлан мэдээг нууцалж, нөгөө талын зөвшөөрөлгүй гуравдахь этгээдэд өгөхгүй. Дээр өгүүлсэн нууцлалын талаар хүлээх үүрэг нь дараах зүйлд хамаарахгүй. Үүнд: 1. Аль нэг тал өөрийн ажиллагсад, хувь нийлүүлэгчид, зөвлөгчид, оролдох ирээдүйтэй этгээдүүд, зээл олгох этгээдүүд, мөн оролцон гүйцэтгэгчдэд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах шаардлагын хэмжээнд нууцлалтыг задлах бөгөөд гэхдээ нууцлалыг задлахаас өмнө нууцыг задлагч тал түүнийг мэдэх хувь хүмүүс буюу хуулийн этгээдээс бичгээр тохиролцсон баталгаа гаргуулж авна. 2. Дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд аль нэг тал нь нууцыг задалж болно.

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ
НЯГТЛАН БОДОХ МЭДЭЭЛЭЛ

13. 1. Нягтлан бодох бүртгэл

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг "С" хавсралтад заасан тооцооны журам болон олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нягтлан бодох бүртгэлийн нийтлэг зарчмуудын дагуу хөтөлнө. Эдгээр нягтлан бодох бүртгэлийг АНУ-ын доллараар тооцоолж, англи хэл дээр хөтөлнө.

13. 2. Нягтлан бодох бүртгэлийн тайлан

Гэрээлэгч нь монголд өөрийн төлөөлөгчийн газраа нээх хүртэл нягтлан бодох эдгээр бүртгэл, тайланг Засгийн газрын төлөөлөгчид гаргаж өгч байна. Гэрээлэгч монголд төлөөлөгчийн газраа нээсний дараа ийм нягтлан бодох бүртгэлийн хувийг төлөөлөгчийн газартаа байлгах бөгөөд Засгийн газрын төлөөлөгч нь түүнтэй дуртай цагтаа танилцах эрхтэй. Гэрээлэгч нь нягтлан бодох бүртгэлийн тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу Засгийн газрын төлөөлөгчид улирал тутам гаргаж өгнө.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР ЗҮИЛ
ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭМЖЛЭГ
ТУСЛАЛЦАА

14. 1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж, энэ гэрээний зорилгыг биелүүлэхийн тулд гэрээлэгч нь МГТ компаниас дэмжлэг туслалцаа хүснэ гэдгийг талууд хүлээн зөвшөөрч байна. Тухайлбал, МГТ компани нь Монгол улс ба гэрээлэгчийн хувьд энэхүү гэрээний зорилтыг харилцан ашигтайгаар хэрэгжүүлэх үүднээс гэрээлэгчид боломжийн хэмжээгээр холбогдох эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх боломжийг олгоход зохих тусламж дэмжлэгийг үзүүлэх бөгөөд тухайлбал, Засгийн газрын зөвшөөрөл, бүртгэл, лицензи, виз, зөвшөөрөл болон гэрээлэгчээс газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад шаардагдах бусад зөвшөөрөл, эрх олж авахад нь тусална. Гэрээлэгчийн хүсэлтээр Засгийн газрын төлөөлөгч нь түүнд туслуулахаар өөрийн нэг буюу хэд хэдэн төлөөлөгчийг орон тооны ажилтнаар томилох бөгөөд гэрээлэгч нь тэр төлөөлөгчийн зохих зардлыг Засгийн газрын төлөөлөгчтэй урьдчилан тохиролцсон хэмжээгээр хариуцан төлнө.

АРВАНТАВДУГААР ЗҮИЛ
ӨМЧИЙГ ЭЗЭМШИХ БА ӨМЧЛӨХ

15. 1. Энэ гэрээнд өөрөөр заагаагүй бол газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад ашигласан, гэрээт талбай дээр байгаа, гэрээлэгч өртөг, зардлыг нь энэ гэрээний дагуу нөхөж авсан гэрээлэгчийн бүрэн эзэмшлийн бүх тоног төхөөрөмж, барилга байгууламж болон материал нь энэ гэрээ дуусгавар болсны дараа нэмэгдэл төлбөргүйгээр Монгол улсын төрийн өмч болно. Энэхүү 15. 1-ийн заалт нь гэрээлэгч өөрийн хувь нийлүүлэгчээс болон өөр аль нэг этгээдээс түрээсээр авч ашигласан эд зүйлд хамаарахгүй гэдгийг харилцан ойлголцов.

15. 2. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахын тулд гэрээлэгчийн барьж байгуулсан буюу олж авсан бүх барилга

Handwritten signature

бай
хуг
али
гэр
тал
15.1
ба
бую
гэр
16.1
шаар
гэр
зүйл
маши
зүйл
тохи
16.2
гадн
Үүнд
дото
ажил
байх
заас
улс
16.3

байгууламж болон бусад зүйл энэ гэрээг хүчин төгөлдөр байх хугацаанд гэрээлэгчийн онцгой хэрэглээнд Засгийн газрын зүгээс аливаа хураамж, төлбөргүйгээр байх бөгөөд энэ нь тэдгээр зүйлүүд гэрээт талбайд, эсвэл гэрээт талбайн гадна, эсвэл анхдагч гэрээт талбайн буцааж өгсөн хэсэг дээр байгаа эсэхээс үл хамаарна.

15. 3. ҮШ, 1Х зүйлийн дагуу гэрээлэгчийн хуваарьт гэрээт түүхий тос ба гэрээт хий нь бүтээгдэхүүн хуваах хэмжилт хийсэн цэгүүд дээр буюу гэрээлэгч, МГТ компанийн тохиролцсон бусад цэгүүд дээр гэрээлэгчид шилжинэ.

АРВАНЗУРГААДУГААР ЗҮЙЛ ГААЛИЙН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ

16. 1. Гэрээлэгчийн гаднаас оруулах зүйл

Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад гэрээлэгчид шаардлагатай бүх зүйл оруулахыг зөвшөөрөх бөгөөд эдгээр зүйлд гэрээлэгчээс гаалийн татвар төлөхөөс чөлөөлнө. Ийнхүү чөлөөлөгдөх зүйлд бүх материал, тоног төхөөрөмж болон бусад зүйл тухайлбал, машин техник, автомашин, сэлбэг, дугуй, химийн бодис, хүнсний зүйл, өргөн хэрэглээний бусад бараа хамаарна гэж хэлэлцэн тохиролцов.

16. 2. Ажиллагсадын гаднаас оруулах зүйлс

Гэрээлэгчийн гадаадын харьяат ажиллагсад нь дараах зүйлийг гаднаас оруулж болох бөгөөд гаалийн татвар төлөхөөс чөлөөлөгдөнө. Үүнд: гэр ахуйн хэрэглэл, хувийн хэрэглээний бусад зүйл, үүний дотор нэг автомашин орно. Гэхдээ эдгээр зүйл нь зөвхөн уг ажиллагсадын болон тэдний гэр бүлийн хэрэглээний зориулалттай байх бөгөөд тэднээс тийнхүү оруулсан зүйлийг хууль тогтоомжинд зааснаас өөр зорилгод хэрэглэх, зохих зөвшөөрөлгүйгээр Монгол улсад зарж борлуулахыг хориглоно.

16. 3. Монгол улсад эдэлгээнээс хасагдсан зүйлс

Гэрээлэгчийн гаднаас оруулсан аливаа эд зүйлийг зохих татвар

DL il

84

хураамжийг зарж борлуулах үеийн үнээр тооцон төлсөн тохиолдолд Монгол улсад зарж борлуулж болно. Гэрээлэгчийн гаднаас оруулсан бөгөөд зөвхөн хаягдал түүхий эдийн үнээр борлуулсан буюу борлуулах зүйлийг дээр заасны адилаар худалдаж болно. Гэрээлэгч нь энэхүү 16.3-т заасны дагуу худалдаж олсон орлогоо энэ гэрээнд заасны дагуу чөлөөт валютаар еөртөө авах, гадаадад гаргах эрхтэй.

16.4. Экспорт

а. Гэрээлэгч буюу түүний ажиллагсадаас Монгол улсад оруулсан бөгөөд МГТ компанийн эмч хөрөнгө биш аливаа зүйлийг ямар нэг татвар, бусад хураамж төлөхгүйгээр буцаан гаргаж болно.

б. Монгол улсаас гэрээлэгчийн гаргаж байгаа газрын тосыг газрын тосны экспорттой холбоотой татвар, бусад хураамжаас чөлөөлөх бөгөөд газрын тосыг Монгол улсаас гаргахад ямар нэг тусгай зөвшөөрөл авсан байхыг шаардахгүй.

в. Гэрээлэгчийн оролцон гүйцэтгэгчид, тэдгээрийн ажиллагсад нь энэхүү ХҮ1 зүйлд заасан гэрээлэгч, түүний ажиллагсадын нэгэн адил эрх эдэлнэ.

АРВАНДОЛООДУГААР ЗҮЙЛ
ВАЛЮТЫН СОЛИЛЦООНЫ ЭРХ

17.1. Гадаад валют

Гадаад валютыг худалдан авах буюу худалдахад Монгол банкны тогтоосон тухайн өдрийн давамгайлах ханшийг хэрэглэнэ.

17.2. Гадаадын банкин дахь данс

Гэрээлэгч нь Монгол улсын хилийн чанадад гадаадын банкуудад аливаа валютаар данс нээх, хадгалах, хянах, гүйлгээнд ашиглах, мөн эдгээр дансыг бүрэн хяналтандаа байлгах, ийм дансанд байгаа мөнгөн хөрөнгөө чөлөөтэй ашиглах болон гадаадад байлгах эрхтэй.

17.3. Валют солих эрх

Гэрээлэгч нь валют солихдоо дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

34

35

а. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах бүх мөнгөн санг чөлөөт валютаар нийлүүлж, эдгээр валютыг 17.1-д заасан ханшаар Монгол банкаар дамжуулан төгрөгөөр солих,

б. Монгол улсын хилийн чанадад мөнгөн хөрөнгөтэй байж, түүнийгээ чөлөөтэй зарцуулах,

в. Газрын тосыг экспортлох, худалдах буюу солих замаар Монгол улсын хилийн чанадад олсон бүх орлогоо гадаадад байлгах, чөлөөтэй зарцуулах,

г. Газрын тосыг Монгол улсын нутаг дээр худалдах, солих, экспортлох замаар Монгол улсад олсон бүх орлогоо гадаадад гаргах буюу чөлөөтэй зарцуулах,

д. Өөрийн оролцон гүйцэтгэгч болон гадаад орны харьяат ажиллагсадаа Монгол улсад буюу еер оронд гадаад валютаар цалин олгох. Эдгээр ажиллагсад нь зөвхөн өөрийн амьжиргааны хэрэгцээг хангах зориулалт бүхий гадаад валютыг Монгол улсад оруулах,

е. Энэ гэрээний дагуу Монгол улсад төлөх төлбөр, эсвэл газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардлагатай бусад төлбөрийг гүйцэтгэхийн тулд гэрээлэгчийн сонгож авсан монголын аль нэг банкинд еер орны валютын тусгай данстай байх.

17.4. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх төлбөр

Талууд энэ гэрээний дагуу гүйцэтгэх төлбөрийг хэрэв еер валютаар харилцан тохиролцоогүй бол АНУ-ын доллараар хийнэ.

17.5. Оролцон гүйцэтгэгчид

Гэрээлэгчийн оролцон гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллагсад нь энэ ХҮП зүйлд заасан гэрээлэгч болон түүний ажиллагсадын адил эрх эдэлнэ.

АРВАННАИМДУГААР ЗҮЙЛ МОНГОЛЫН ГЭРЭЭЛЭГЧИД, МАТЕРИАЛ, АЖИЛЛАГСАД

Гэрээлэгч ба түүний оролцон гүйцэтгэгчид нь: 1. Монголын оролцон гүйцэтгэгчийн ажлын хөлс, мэргэжлийн чадвар нь олон улсын

19. үзүүлэлттэй жишиж болох нөхцөлд юуны өмнө монголын оролцон гүйцэтгэгчийг сонгож авахыг урьтал болгоно. 2. Монголд үйлдвэрлэсэн материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон өргөн хэрэглээний барааны үнэ, чанар, тэдгээрийг нийлүүлэх хугацааг гадаадаас авч болох материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, өргөн хэрэглээний бараатай жишиж болох нөхцөлд юуны өмнө Монголд үйлдвэрлэсэн эдгээр зүйлийг сонгож авахыг урьтал болгоно. 3. Хүн авч ажиллуулахдаа юуны өмнө зохих ёсны мэргэжилтэй монголын иргэдийг сонгож авахыг урьтал болгоно. Гэхдээ гэрээлэгч нь гол гол албан тушаалд өөрийн ажиллагсадыг ажиллуулах эрхтэй. Монголын иргэдийг монголын хууль тогтоомжийн дагуу МГТ компаниар дамжуулан цалинжуулна. Гэрээлэгч нь монголын оролцон гүйцэтгэгч, монголд үйлдвэрлэсэн бараа материал болон монголын ажиллагсадыг олж авахын тулд Засгийн газрын төлөөлөгчөөс дэмжлэг тусалцаа үзүүлэхийг хүсэх ба энэ ХҮШ зүйлийн дагуу гэрээлэгчийн хүлээх үүрэг, нөхцөлийг Засгийн газрын төлөөлөгчөөс гэрээлэгчид урьдчилан мэдэгдсэн байхыг хүлээн зөвшөөрөв. 4. Гэрээлэгч нь гэрээний дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэж яваад үйлдвэрлэлийн ослоор хөдөлмөрийн чадвараа түр буюу бүр алдсан монголын ажиллагсдад хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу төлнө.

АРВАНЕСДҮГЭЭР ЗҮЙЛ
ОНЦГОЙ ТОХИОЛДЛУУД

19.1. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд гарч болох онцгой тохиолдлууд

Аливаа онцгой байдал тохиолдоход шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг гэрээлэгчид үүгээр олгож байна. Гэрээлэгч нь онцгой байдал тохиолдсон тухай Засгийн газрын төлөөлөгчид аль болох түргэн мэдэгдэнэ.

19. 2. Үндэсний онц байдал

а. Үндэсний онц байдал тогтоосон нөхцөлд Монгол улсын Засгийн газар нь гэрээт талбайгаас олборлох гэрээлэгчийн хуваарьт газрын тосыг бүхлээр нь буюу хэсэгчлэн дайчлан авч болох бөгөөд газрын тосны олборлолтыг аюулгүй дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхийг гэрээлэгчээс шаардаж болно.

б. Газрын тосыг ийнхүү дайчлан авах тухай асуудлаар саналаа илэрхийлэх боломжийг гэрээлэгчид олгосны дараа тосыг авна.

в. Газрын тосны нөөц буюу түүнтэй холбогдох аливаа байгууламжийг дайчлан авах явдал нь Монголын хууль тогтоомжийн дагуу байх бөгөөд зөвхөн гэрээлэгчид зохих ёсоор мэдэгдсэнээр хийгдэх ба үндэсний онцгой байдлыг зогсоох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

г. Дайчлан ашиглах аливаа тохиолдолд Монгол улсын Засгийн газар нь үүнээс болж гэрээлэгчид учирсан бүх алдагдлыг нөхөж хохиролгүй болгоно.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

20.1. Энэхүү ХХ зүйлд дурдсан "Давагдашгүй хүчин зүйл" гэдэг ойлголтод дараах зүйл багтана. Үүнд: гал түймэр, гоц халдварт өвчний тархалт, гарцаагүй тохиолдсон осол, зарласан ба зарлаагүй цайн, ажил хаялт, бөөнөөр нь ажлаас халах болон хөдөлмөрийн бусад эмх замбараагүй байдал, үер, хүчтэй салхи шуурга, газар хөдлөлт болон байгалийн бусад гамшигт үзэгдэл, улс төрийн хавчилт шахалт, үймээн самуун, бослого хөдөлгөөн, Засгийн газрын аль нэг байгууллагын бүтэлгүй буюу удаашралтай ажиллагаа, тухайлбал, гэрээт түүхий тос ба гэрээт хийг монголоос гаргах эсвэл газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд хамаарах материал, тоног төхөөрөмж, мэдээлэл буюу бусад зүйлийг гаднаас оруулах, гадагш гаргах, ашиглахтай холбогдсон аливаа зөвшөөрлийг Засгийн газрын аль нэг эрх бүхий байгууллагаас олгохгүй байх, эсвэл хойшлуулах зэрэг зүйл багтана.

AC
K

20.2. Хэрэв нэг буюу хэд хэдэн үр ашигтай нээлтээс газрын тосны олборлож байсан буюу олборлож болох байсан хэмжээг давагдашгүй хүчин зүйлийн улмаас зогсоосон буюу өөр ямар нэг байдлаар хязгаарласан бол тэдгээрээс газрын тосыг олборлож болох байсан хэмжээнд хүртэл олборлож хуримтлуулахад шаардагдах хугацааг ү зүйлд заасан ашиглалтын хугацаан дээр нэмж сунгана. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх үүднээс хэрэглэсэн "хэмжээ" гэсэн ойлголт нь ашиглалтын үйл ажиллагааг зогсоогоогүй тохиолдолд үр ашигтай нээлт буюу нээлтүүдийн хүрээнд өрөмдсөн цооногуудаас олон улсын газрын тосны үйлдвэрлэлд хэвшсэн нийтлэг практикийн дагуу олборлож болох байсан нийт газрын тосны хэмжээг хэлнэ. Гэрээлэгч нь энд заасан олборлох ёстой газрын тосны нийлбэр хэмжээний талаар Засгийн газрын төлөөлөгчид хуанлийн жил бүрээс хойш 90 хоногийн дотор мэдэгдэж байна.

ХОРИННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ ГЭРЭЭ ЦУЦЛАХ

21.1. Хэрэв энэ гэрээнд гарын үсэг зурсны дараа 120 хоногийн дотор гэрээ хүчин төгөлдөр болохгүй бол гэрээлэгч нь Засгийн газрын төлөөлөгчид гэрээг цуцлахаа мэдэгдэж болно.

21.2. Хэрэв гэрээлэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор хайгуулын хөтөлбөрт ажлаа эхлээгүй бол Засгийн газрын төлөөлөгч нь энэ гэрээг цуцлахаа мэдэгдэж болно.

21.3. Хэрэв гэрээлэгч нь мэдсээр атлаа энэ гэрээг зөрчих аваас, тухайлбал, эд материалын зөрчил гаргаад түүнийг энэ гэрээнд заасан хугацаанд арилгаагүй буюу арилгаж эхлээгүй, мөн гэрээг хэрэгжүүлэх үүднээс төсөвт ажлаа эхлээгүй бол Монгол улсын Засгийн газар энэ гэрээг цуцлах эрхтэй.

21.4. Хэрэв Монгол улсын Засгийн газар 21.2-т, 21.3-т заасан эрхээ хэрэгжүүлэхээр шийдвэл Засгийн газрын төлөөлөгч гэрээлэгчид

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

бичгэ
дотор
эхлээ
буюу
үүний
болно
Ийм ш
заалт
нь ту

21.5.1
гэрээг
холбо
буюу
Монгол

22.1.1
гарах
цуцлах
бол эн

Олон у
дагуу
бөгөөд
чөлөөт
болох
талууд
агуула

22.2.1
байгуу
түүнчл
үйлдвэ

2011

бичгээр мэдэгдэл өгч болно. Мэдэгдэл өгснөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч нь дээрх зөрчлийг арилгаагүй буюу арилгаж эхлээгүй бол зөрчлийг тийнхүү арилгахад нь гэрээлэгчид Монгол улс буюу давагдашгүй хүчин зүйл саад болоогүй буюу тасалдуулаагүй бол үүний дараа энэ гэрээг цуцлах тухай шийдвэрийг Монгол улс гаргаж болно.

Ийм шийдвэрийн эсрэг гэрээлэгч нь ХХП зүйл дэх арбитрайн тухай заалтыг ашиглах эрхтэй. Гэрээг цуцалсан тохиолдолд ч гэрээлэгч нь тухайн гэрээт жилийн ажил үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

21. 5. Ийм цуцлалт нь Монгол улс ба гэрээлэгчийн эрхийг хөндөхгүй, гэрээг ийнхүү цуцалсны дараа гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахдаа хэрэглэхээр түрээсээр авсан буюу гэрээлэгчийн бүрэн эзэмшлийн бус бусад бүх эд хөрөнгөө Монголоос авч гарах эрхтэй.

ХОРИНХОЕРДУГААР ЗҮЙЛ
АРБИТР

22. 1. Гэрээнд оролцогч талуудын хооронд уг гэрээтэй холбогдон гарах (түүнийг хэрэгжүүлэх, тайлбарлах, хэрэглэх, хугацаа дуусах, цуцлах, эсвэл сунгах) аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлээгүй бол энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед хүчинтэй байсан НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн байгууллагын арбитрайн дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ. Бүх үйл ажиллагааг англи хэл дээр явуулах бөгөөд Швейцарын Цюрих хотод хийнэ. Арбитрч нар нь англи хэлийг чөлөөтэй эзэмшсэн байна. Арбитрайн зөвлөлийн шийдвэр нь эцсийнх болох бөгөөд энэ нь үйл явдлыг саатуулах, эсвэл удаашруулах талуудын сонирхлоос гадна тусгайлсан зориудын хор хөнөөллийг агуулах ёсгүй.

22. 2. Гүйцэтгэгч болон Монгол улс, хоршооллын болон улсын байгууллагууд, үйлдвэрийн газрууд, хувь хүмүүсийн хооронд, түүнчлэн гүйцэтгэгч болон гадаадын хөрөнгө оруулагч компани, үйлдвэрийн болон бусад газрууд, мөн хувь хүмүүсийн хооронд

Handwritten initials/signature

гэрээлэгчийн үйл ажиллагаатай холбогдсон аливаа маргаан гарвал Монгол улсын шүүх болон арбитрын байгууллага өөрсдийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэнэ.

22.3. Газрын тосны гэрээнд оролцогч тал болсон гадаадын аль нэг хөрөнгө оруулагч нь газрын тосны гэрээтэй холбоотой буюу түүнээс үүдсэн аливаа маргаан, зөрчилдөөн, гомдлыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох өдөр хүчинтэй байсан НҮБ-ын олон улсын худалдааны эрх зүйн байгууллагын арбитрийн дүрмийн дагуу арбитраар хянан шийдүүлнэ.

22.4. Шийдвэр гартал гэрээлэгч нь шийдвэртэй холбоотой, эсвэл түүнд нөлөө үзүүлж болох бүх ажиллагаагаа болон бусад ажлаа зогсоох буюу хааж болох боловч энэ тухай түүнээс шаардахгүй. Хэрэв гарсан шийдвэр нь гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл тэр шийдвэрт нөхөж төлөх тухай заалтыг гомдол гаргагчид ашигтайгаар тусгах ба харин гомдлын аливаа шалтгааныг шийдвэр гарсан өдрөөс хойш 90 хоногийн хугацаанд арилгаж эхэлнэ.

22.5. Арбитрийн шийдвэрийг зохих эрх мэдэл бүхий шүүхэд шилжүүлж, мөн шүүхэд хандан, уг шийдвэрийг хууль зүйн хувьд хүлээн авч хэрэгжүүлэх дарааллыг тогтоож өгөхийг хүсч болно.

22.6. Шийдвэрүүдийг хэрэгжүүлж эхлэх хугацааг боломжтой бүх тохиолдолд уул шийдвэрүүдэд зааж өгөхийг талууд хүсч байгаа бөгөөд харин гэрээлэгчийн эсрэг гарсан аливаа шийдвэрт заасан хугацаа нь аль ч тохиолдолд 90 хоногоос багагүй байна.

22.7. Гэрээнд оролцогч талууд нь энэ гэрээтэй холбогдсон өөрсдийн харилцаагаа сайн санаа, итгэлцлэлийн зарчимд үндэслэнэ. Талууд өөр өөр улс үндэстнүүдийг төлөөлж байгааг харгалзан энэхүү гэрээг Монгол улсад болон гэрээлэгчийн эх оронд тогтсон түгээмэл зарчмуудад нийцүүлж хэрэгжүүлэх бөгөөд ийм түгээмэл зарчим үгүй нөхцөлд арбитр нь олон улсын газрын тосны үйлдвэрлэлийн хэвшсэн зарчмуудыг баримтална.

ХОРИНГУРАВДУГААР ЗҮИЛ

МЭДЭГДЭЛ

23.1. Гэрээлэгчид бичгээр өгөх мэдэгдэл нь телексээр явуулж, түүнийг хүлээж авсан тухай хариу өгсөн тохиолдолд хүчин төгөлдөр болно. Гэрээлэгч нь Монгол улсад төлөөлөгчийн газраа нээсний дараа Засгийн газрын төлөөлөгчөөс гэрээлэгчид өгөх мэдэгдэл нь дараах тохиолдолд хүчин төгөлдөр байна. Үүнд: 1. Ийм төлөөлөгчийн газарт ажиллаж буй гэрээлэгчийн төлөөлөгчид болон 23.3-т заасан гэрээлэгчийн удирдах төвд телекс явуулж, түүнийг хүлээн авсан тухай хариу авсан байх, эсвэл 2. Өнэ төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гэрээлэгчийн төлөөлөгчид элчээр хүргүүлж, түүнийг хүлээн авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдэгдлийг биечлэн хүргэх ба аль ч тохиолдолд гэрээлэгчийн төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс нь хүлээн авсан тухай хариу авсан, мөн мэдэгдлийн хувийг 23.3-т заасан гэрээлэгчийн удирдах төвд телексээр явуулж, хүлээн авсан тухай хариу авсан байх зэрэг болно.

23.2. Гэрээлэгчээс Засгийн газрын төлөөлөгчид бичгээр өгөх мэдэгдэл нь дараах тохиолдолд хүчин төгөлдөр байна. Үүнд: 1. Мэдэгдлийг Засгийн газрын төлөөлөгчид телексээр явуулж, хүлээж авсан тухай хариу авсан байх, эсвэл 2. Засгийн газрын төлөөлөгчийн ажлын газарт элчээр хүргүүлж, түүнийг хүлээж авсан нотолгоог авсан байх, эсвэл тийм мэдээллийг биечлэн хүргэх ба аль ч тохиолдолд Засгийн газрын төлөөлөгч буюу түүний эрх мэдэл бүхий төлөөлөгчдийн нэгнээс мэдэгдлийг хүлээн авсан тухай хариу авсан байх зэрэг болно.

23.3. Дээрх 23.1 ба 23.2-т заасан мэдэгдлийг дараах хаягаар илгээнэ. Үүнд:

а. Монгол улсын Засгийн газрын төлөөлөгч Д. Сэнгээ, МГТ компанийн ерөнхий захирал, телекс: 79235, МГТ МН, факс: 976-1-331176, Монгол улс, Улаанбаатар-37, Үйлдвэрчний гудамж, МГТ

б. Гэрээлэгч Х. С. Финкелстейн Медаллион Монгол ойл компанийн

ерөнхийлөгч, телекс: 765-242, факс: (713) 654-1524, телефон
(713) 654-0144, АНУ Хьюстон, Техас 77002, Фаннин Стрийт 1407.

23.4. Нөгөө талдаа 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх үндсэн дээр аль нэг тал нь мэдэгдэл хүлээж авах хаягаа өөрчилж болно. Гэхдээ уг шинэ хаяг нь нөгөө талд аливаа хэлбэрийн зохимжгүй чирэгдэл учруулахгүй байх ёстой.

23.5. Аль нэг тал нь нөгөө талын мэдэгдлийг хүлээж авахаа татгалзах буюу хүлээж авах боломжгүй тохиолдолд нөгөө талын эрх ямар ч байдлаар буурах буюу хөндөгдөх өсгүй.

ХОРИНДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ ЭРХ ШИЛЖҮҮЛЭЛТ

24.1. Анхдагч гэрээлэгч болон гүйцэтгэгч бус дараагийн гэрээлэгч нь Монгол улсын Засгийн газрын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрсдийн эрх үүргийг бүрнээр буюу аль нэг хэсгийг бусдад шилжүүлж болохгүй. Ийм хүсэлтийг үндэслэлгүйгээр татгалзахгүй.

24.2. Хэрэв гэрээлэгч нь газрын тос олж илрүүлээд газрын тос тас холбогдсон аливаа үйл ажиллагаанд зориулж, нэг ба түүнээс дээш тооны зээлдүүлэгч байгууллагаар санхүүжилт хийлгэхийг хүсвэл тийм зээлдүүлэгч байгууллагуудад баталгаат хүү төлөх нөхцөлтэйгээр зөвшөөрөлгүйгээр хүлээсэн эрх ба үүргээ бүрнээр нь эсвэл аль нэг хэсгийг нь Монголын Засгийн газрын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу дээр байгууллагуудад шилжүүлж болох бөгөөд тийм зөвшөөрөл олгохыг Монголын Засгийн газар үндэслэлгүйгээр татгалзахгүй.


24.3. Энэхүү ХХ1Ү зүйлийн заалтуудын дагуу энэ гэрээ нь түүний оролцогч талууд, тэднийг залгамжлагчид болон эрх шилжүүлэн авах этгээдүүдийн хувьд дагаж мөрдөгдөх бөгөөд тэдний эрх ашиг үйлчилнэ.

ANNEX A, B

CONTRACT AREA

BLOCK-XIX TOSON UUL

ФОН:
дээр
хцээ
гдэл
хаас
эр
гчид
гээр
үүлд
СТО
Дээр
Тий
Эн
гий
ээр
хоо
үүн
вса
шиг
С



ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

ХОРИНТАВДУГААР ЗҮЙЛ
ЕРӨНХИЙ ЗААЛТ

25. 1. Хавсралтууд

Хавсралт А, В, С₁^Е болон Д нь энэхүү гэрээний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийн заалтууд нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

25. 2. Хуулиуд

Гэрээлэгч нь Монгол улсын хуулийг дагаж мөрдөх бөгөөд гэрээлэгчийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэ гэрээний дагуу түүний эрхийг үгүйсгэхгүй, эсвэл өөрчлөхгүй.

25. 3. Сайн санаа

Талууд энэхүү гэрээний дагуу харилцаагаа сайн санааны зарчимд үндэслэж, хамтын зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө зохих ёсоор хамтран ажиллаж, гарч болох аливаа үл ойлголцох явдал, маргааныг эв зүйгээр зохицуулан энэ гэрээнд заасан аливаа зөвшөөрлийг олгох, эсвэл хойшлуулахыг үндэслэлгүйгээр татгалзахгүй.


25. 4. Гэрээний хэл

Гэрээг монгол болон англи хэл дээр үйлдэв. Монгол болон англи хэл дээрх хувилбаруудын хооронд ямар нэгэн зөрчил гарвал англи хэл дээрх хувилбарыг голлон баримтална.

Дээр дурдсан бүх зүйлийг нотлон Засгийн газрын төлөөлөгч болон гэрээлэгч энэхүү гэрээг 1993 оны дөрөвдүгээр сарын 26-нд байгуулсан бөгөөд энд заасны дагуу хүчин төгөлдөр болно.


ДООВАТЫН СЭНГЭЭ

МОНГОЛ ГАЗРЫН ТОС КОМПАНИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ


Х. С. ФИНКЕЛСТЕИН

МЕДАЛЛИОН МОНГОЛ ОЙЛ КОМПАНИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ ГАЗРЫН ТОС КОМПАНИ БОЛОН
МЕДАЛЛИОН МОНГОЛ ОИЛ КОМПАНИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
ХУВААХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ
"С" ХАВСРАЛТ

ТООЦООНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Ерөнхий заалтууд

1.1. Зорилго

Энэхүү бүртгэл тооцооны журмын зорилго нь гэрээний дагуу гарах өртөг, зардал, бараа материалын нөөцийн орлого, зарлагыг тодорхойлох эрх тэгш арга замыг тогтооход оршино. Хэрэв эдгээр арга замын аль нэг нь гэрээлэгч буюу Монгол улсын Засгийн газрын хувьд шударга, эрх тэгш бус болох нь нотлогдвол, талууд уулзаж, дээрх арга замын шударга, эрх тэгш бус аливаа зүйлийг залруулахад шаардлагатай өөрчлөлтүүдийн талаар тохиролцохыг хичээнгүйлэн эрмэлзэнэ.

1.2. Нэр томъёо

Энэхүү бүртгэл тооцооны журмыг хэрэгжүүлэх үүднээс энд хэрэглэсэн нэр томъёоны агуулга нь өөрөөр илэрхий заагдсанаас бусад тохиолдолд энэхүү гэрээнд тодорхойлсон нэр томъёонууд нь "С" хавсралт гэж гэрээнд хавсрагдсан, бүртгэл тооцооны журамд заасан нэр томъёотой адил утга агуулгатай байна.

1.3. Баримт бичгийн давамгайлах байдал

Энэхүү бүртгэл тооцооны журам, гэрээний хооронд үл тохирох буюу зөрчилдөх аливаа тохиолдолд гэрээг баримтална.

1.4. Үйл ажиллагааны тухай тайлан мэдээ

Гэрээлэгч нь хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн улирал бүр

PP

дууссаны дараа 90 хоногийн дотор тухайн улиралд явуулсан газрын тостой холбогдсон үйл ажиллагааны олборлолт, орлого, зарлагыг тусгаж дээрх үзүүлэлтүүдийг зохих ангиллаар нэгтгэн дүгнэсэн үйлдвэрлэл, өртөг нөхөлтийн тайлан мэдээг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойших байдлаар дүгнэсэн хураангуй мэдээллийн хамт Засгийн газрын төлөөлөгчид бүрдүүлж өгнө.

1.5. Залруулга ба шалгах

Засгийн газрын төлөөлөгч нь гэрээлэгчээс үйлдвэрлэл ба өртөг нөхөлтийн тухай тайлан мэдээ нэг бүрийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр жилийн дотор тухайн тайлангийн бүртгэл тооцоо, туслах баримт бичгийг шалгах эрхтэй. Гэрээлэгч нь дээрх хоёр жилийн хугацаанд ийм бүртгэл тооцоо, туслах баримт бичиг буюу үйлдвэрлэл, өртөг нөхөлтийн тухай тайланд гарсан аливаа алдааг засах эрхтэй. Үйлдвэрлэл, өртөг нөхөлтийн тухай аливаа тайлан буюу түүний хэсгийн талаар Засгийн газрын төлөөлөгчөөс бичгээр мэдэгдэл гаргаагүй, эсвэл бичгээр гаргасан мэдэгдлийн шалтгааныг зохицуулсан бол дээрх мэдээ тайлан гаргаж өгсөн өдрөөс хойш хоёр жилийн эцэст эдгээрийг үнэн зөв гэж тооцох бөгөөд цаашид шалгахгүй. Тэрчлэн, үйлдвэрлэл, өртөг нөхөлтийн тухай аливаа тайлан буюу түүний хэсгийг хянаагүй, эсвэл хянасан боловч эргэж хянаж үзэхгүй бол дээрх мэдээ тайланг гаргаж өгсөн өдрөөс хойш хоёр жилийн эцэст эдгээрийг үнэн зөв гэж тооцох бөгөөд цаашид хянахгүй.

1.6. Валют солих

АНУ-ын доллараар хийсэн зарлагыг жинхэнэ зарцуулсан хэмжээгээр нэхэмжилнэ. АНУ-ын доллараас бусад валютаар хийсэн зарлагыг тухайн валютыг сольж авсан тухайн үеийн ханшийг баримтлан АНУ-ын долларт шилжүүлэн тооцно. Бусад валютыг АНУ-ын долларт шилжүүлэхэд баримталсан ханшны бүртгэл тооцоог хөтөлж байна.

Handwritten signature or initials.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Өртөг, зардал

2.1. Нөхөн төлөгдөх зардал

Гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахтай холбогдон гэрээлэгч болон хувь нийлүүлэгч дараах өртөг зардлыг нөхөж авна. Үүнд:

а. Ажиллагсад

1. Энэ гэрээний дагуу төрөл бүрийн үйл ажиллагаанд тогтмол буюу ажлын бүрэн цагаар ажиллахаар томилогдсон буюу оролцсон ажиллагсадын цалин, хөлс болон дээрх үйл ажиллагаанд түр хугацаагаар буюу ажлын бүрэн бус цагаар ажиллахаар томилогдсон буюу оролцсон ажиллагсадын цалин, хөлсний зохих хувь хэмжээ. Дээрхийг үл хязгаарлан тайлбарлах үүднээс, энэ зүйлийн 2.1(н)1-д заасан ажиллагсадын цалин, хөлсийг дээрх ажиллагсад нь Монгол дахь ийм үйл ажиллагаанд томилогдсон буюу оролцсон, эсвэл Монгол улсад буюу Монгол улсаас ирэх буцах хүрээнд л энэхүү 2.1(а)1-д заасны дагуу нөхөж авна.

П. Ажиллагсадын цалин, хөлсөнд хамаарах амьжиргаа, орон байрны зардал, баяр еслолын өдрүүдийн амралт, өвчлөлт, ээлжийн амралт болон хөдөлмөрийн чадвар алдахад олгох хөнгөлөлт, урамшуулал, илүү цагийн болон бусад хөлсийг төлөхөд гарах өртөг зардал

Ш. Бүх ажиллагсадын амь даатгах, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх, тэтгэвэр тогтоох, чөлөөнд гарах, хувьцаа худалдаж авах, хадгаламжийн дэвтэр нээх зэрэг хөнгөлөлттэй холбогдон гарах өртөг зардал

1Ү. Хөдөлмөрийн гэрээ цуцалсны тэтгэмжийг Монгол улсын хөдөлмөрийн хуульд заасан хэмжээний хамгийн дээд түвшингээр тооцож, цалингийн тогтмол хувиар бодож олгоно.

б. Үйлчилгээ

1. Гуравдахь этгээдээс зөвлөгч авах, гэрээт болон ахуйн үйлчилгээгээр үйлчлүүлэхтэй холбогдох зардал

П. Гэрээлэгч буюу хувь нийлүүлэгчээс Монголд байгаа, эсвэл хилийн чанад дахь байгууламжид гэрээний дагуу зардлыг нь шууд нөхөж авахгүй ажил үйлчилгээ хийхэд гарах зардал. Гэрээлэгчийн буюу хувь нийлүүлэгчийн бүрэн мэдлийн өмч болох тоног төхөөрөмжийг ашигласны төлбөрийг нэхэмжлэхдээ өмч эзэмшлийн болон ашиглалтын зардлаас бодож тогтоосон түрээсийн тарифыг баримтлах боловч энэ тариф нь Монголд тухайн үед мөрдөж буй өрсөлдөхүйц тарифаас хэтрэхгүй.

Ш. Гэрээний 14.1-д заасны дагуу Засгийн газрын төлөөлөгчийн зүгээс үзүүлсэн ажил үйлчилгээтэй холбогдон гарах зардал

в. Хуулийн зардал

Энэ гэрээтэй холбогдон шаардагдах шүүх хурал буюу хууль зүйн бусад үйлчилгээ, үүний дотор хуулийн зөвлөгчдөд өгөх хөлс харамж, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар талуудын болон аль нэгний нь эсрэг шийдвэр гарсантай холбоотой зардал, мөн газрын тостой холбогдсон үйл ажиллагаа буюу энэ гэрээний эсрэг чиглэсэн аливаа үйлдэл, гомдол, заргаас хамгаалах зорилгоор гэрээнд оролцогч талууд буюу аль нэг тал нь урьдчилан сэргийлэхээр авах арга хэмжээний зардлууд энд багтана.

г. Газрын түрээсийн төлбөр ба замын зөвшөөрөл

Монгол улсын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын Х хэсгийн 15.4 болон Ш хавсралтад заасан газрын түрээсийн төлбөр, замын зөвшөөрөл, газар эдэлбэрийн бусад эрхийг олж авах, шинэчлэх, буцааж өгөхтэй холбогдон гарах зардал энд багтана.

д. Захиргааны шимтгэл

Монгол улсын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам, 1Ү хэсэг, 12.1 зүйл, хавсралт III-т зааснаар захиргааны шимтгэлийг МГТ компанид шууд төлнө.

е. Материал

Гэрээлэгчийн худалдаж авсан буюу нийлүүлсэн материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн зардал

1. Худалдаж авсан материал

Гэрээлэгчийн худалдаж авсан тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслийн зардлыг нөхөхдөө гэрээлэгчид үзүүлсэн элдэв хөнгөлөлтийг нь хасаад түүний жинхэнэ төлсөн үнээр нь нэхэмжилнэ.

П. Гэрээлэгч буюу хувь нийлүүлэгчийн нийлүүлсэн материал

Гэрээлэгч нь аливаа материалыг өөрийн буюу хувь нийлүүлэгчийнхээ нөөцөөс авч нийлүүлснээс бусад тохиолдолд материалыг боломжтой үедээ шууд худалдаж авна. Гэхдээ гэрээлэгчийн өөрөө нийлүүлсэн материалын үнэ нь даатгал, нийлүүлэлтийн адил нөхцөлд гуравдахь этгээдээс төсөөтэй эд зүйлийг худалдаж авч болох үнээс өндөр байх есгүй.

Ш. Гэрээлэгчийн нийлүүлсэн материалын баталгаа

Гэрээлэгч нь нийлүүлж байгаа материалдаа үйлдвэрлэгчийн буюу худалдагчийн баталгаанаас гадна ямар нэгэн баталгаа нэмж гаргахгүй бөгөөд хэрэв нийлүүлсэн материал гэмтэл согогтой байвал үйлдвэрлэгч буюу худалдагчаас гэрээлэгчид зөрүүг төлөх хүртэл орлогод авахгүй.

ж. Контор, хээрийн анги, агуулах болон бусад байгууламж

Контор, салбар контор, хээрийн анги, агуулах, холбоо, усан хангамж, зам болон тээврийн бусад систем зэрэг аливаа байгууламжийг ашиглах, тоноглох, тохижуулах, ажиллуулахтай холбоотой зардал

з. Даатгал, гомдол зарга

Хэрэглэгчдэд учирсан хохирлын хариуцлага, өмч хөрөнгийн гэмтэл, улс төрийн үйл явдлаас гарч болох хохирлоос даатгах, мөн ажиллагсад буюу хөндлөнгийн этгээдийн өмнө гэрээлэгч буюу монгол улсын хүлээх хариуцлагын зэрэг бусад даатгалтай холбоотой зардлыг гэрээлэгч хариуцаж болох бөгөөд эсвэл хууль тогтоомжийн дагуу ч шаардаж болно. Ийм даатгалаас буюу гомдол заргаас орох мөнгийг зарлагын эсрэг зохих зүйлд оруулна. Аль нэг тодорхой ажил ослос

тусгайлан даатгуулаагүй бол гарсан аливаа алдагдал, түүнтэй уялдан гарч болох зарга, хохирлыг зохицуулах, шийдвэр гаргуулахтай холбоотой зардлыг зарлагын зохих зүйлээс нэхэмжилнэ.

и. Хохирол болон алдагдал

Гал түймэр, үер, шуурга, хулгай, осол буюу бусад шалтгааны улмаас учирсан хохирол болон алдагдалтай холбоотой зардал. Гэхдээ гэрээлэгч нь АНУ-ын 50 000 доллараас давсан хохирол алдагдлын талаар тухай бүр Засгийн газрын төлөөлөгчид тохиолдсон тухай мэдээлсний дараа буюу гэрээлэгч энэ тухай мэдээ авснаас хойш 5 хоногийн дотор бичгээр мэдэгдсэн байна.

к. Мөнгө солиход олох ашиг ба алдагдал

Гэрээний дагуу мөнгө солих явцад олох ашиг болон алдагдал.

л. Хуу

Олборлолтын зардалд зориулан гэрээлэгч нь зээл авахтай холбоотой үүссэн зардал. Гэхдээ энд заасан хүү нь гэрээлэгч мөнгө зээлсэн тухайн өдрийн Хойд Америкийн СиТи банк буюу түүнийг залгамжлагч аливаа банкнаас ийм хэмжээний зээл олгоход ногдуулдаг хүүний хэмжээнээс хэтрэх ёсгүй.

м. Тээвэрлэлт

Ажиллагсад, тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгсэл болон газрын тос тээвэрлэхэд гарсан зардал. Ажиллагсадын тээврийн зардалд гэрээлэгчээс энэ талаар баримталж буй бодлогын хэмжээнд дараах зүйл багтана. Үүнд: Ажиллагсад болон тэдний гэр бүлийнхэн томилогдон ажиллаж буй газраас ээлжийн амралтаар нутагтаа очих ба буцаж ирэх замын зардал, ажиллагсад болон тэдний гэр бүлийнхэн нэг газраас нөгөө газарт шилжихтэй холбогдсон замын зардал. Гэхдээ ажиллагсад болон тэдний гэр бүлийнхэн Монголд ажиллаж байгаа

газраас өөрийнхөө нутгаас өөр газар шилжихэд гарах замын зардал нь нутаг орондоо буцах тохиолдолд гарах байсан зардлаас хэтрэх есгүй.

н. Бусад зардал

Газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад энэхүү П зүйлд зааснаас бусад зардал.

о. Эх компанийн захиргааны нэмэгдэл зардал

1. Гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад Монгол улсын хилийн чанадад гэрээлэгчийн эх компанийн (үүний дотор хувь нийлүүлэгч багтана) ажиллагсадын гүйцэтгэх ажил үйлчилгээ болон конторын ажилд хамаарах захиргааны нэмэгдэл зардал нь газрын тостой холбоотой гэрээлэгчийн жилийн зардлын хувь байна.

П. Гэрээлэгчийн эх компанийн Монгол улсын хилийн чанадад гарсан бусад захиргааны нэмэгдэл зардлын алиныг ч нөхөн төлөхгүй. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай холбогдуулан гэрээлэгчийн эх компаниас гүйцэтгэж, улмаар дурдсан хувь хэмжээгээр нөхөн төлөгдөх ажил үйлчилгээний жишээнд удирдлага, санхүү, нягтлан бодох, бэлтгэн нийлүүлэх, компьютерын ажил үйлчилгээ ба захиргаа орно.

Ш. 2.1 (м) 1 болон 2.1 (м) П-ын заалтууд нь 2.1 (а) болон 2.1 (б) П-ын дагуух ажиллагсад, ажил үйлчилгээний зардал нэхэмжлэхийг хориглохгүй.

н. Өртөг нөхөх зорилгоор газрын тосны аж үйлдвэрт хэвшсэн практикийн дагуу ийм бүх зардлыг сар тутам хайгуул, урсгал болон ашиглалтын зардалд шингээн хуваарилах буюу шууд нэхэмжилнэ.

2.2. Тооцооны үндэс

Гэрээлэгч нь энэ гэрээтэй холбогдох тооцооны дансыг өссөн дүнгээр хөтөлнө. Энд хэрэглэсэн "өссөн дүнгээр" гэдэг нь тухайн

AC
il

зардлыг хэзээ төлснөөс үл шалтгаалан уг зардлыг гарсан цаг хугацаанд нь хамааруулан тооцохыг хэлж буй болно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Эд хөрөнгийн тооллого

3.1. Тогтмол тооллого хийх, мэдэгдэх, төлөөлөх.

Засгийн газрын төлөөлөгч, гэрээлэгч хоерын хооронд тохиролцсон боломжтой хугацаанд гэрээлэгч нь газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зориулалттай материал, эд хөрөнгийн болон барилгын ажлын төслүүдэд эд хөрөнгийн тооллого хийж, бүртгэл хөтөлнө. Эд хөрөнгийн тооллого явуулахад Засгийн газрын төлөөлөгч, эсвэл түүний томилсон төлөөлөгчийг биечлэн байлцуулахын тулд гэрээлэгч нь тооллого хийх тухай тооллого эхлэхээс наад зах нь 30 хоногийн өмнө Засгийн газрын төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Тооллого явуулахад Засгийн газрын төлөөлөгч байлцаж чадахгүй бол Засгийн газрын төлөөлөгч гэрээлэгчийн хүргүүлсэн тооллогын дүнгийн хувийг хүлээж авах үүрэгтэй.

3.2. Эд хөрөнгийн бүртгэлийг тулган шалгаж, зохицуулах тухай

Гэрээлэгч, Засгийн газрын төлөөлөгч хоёр хамтран эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг тулган шалгаад, илүүдэл буюу дуталтын жагсаалтыг гаргаж, гэрээлэгч нь зөрүүг залруулна.

Г
Ү
Б
Б
Х
О
О
Б
З
Т
Ү
Т
Б
Т
О
О

AL. 12

МОНГОЛ ГАЗРЫН ТОС КОМПАНИ БОЛОН
МЕДАЛЛИОН МОНГОЛ ОИЛ КОМПАНИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
ХУВААХ ТУХАЙ ГЭРЭЭНИЙ
"Е" ХАВСРАЛТ

ТАТВАРЫН ТУХАЙ ЗААЛТУУД

1993 он 4 дүгээр сарын 26-ны өдөр

Орлогын татварын тухай заалтыг хэрэгжүүлэх зорилгоор гэрээлэгч нь орлогын орлон төлөгдөх татварыг төлөх учиртай бөгөөд үүнийг МГТ компани нь гэрээлэгчийн өмнөөс хариуцан төлж барагдуулна. Гэрээлэгчийн өмнөөс МГТ компанийн хариуцан төлж барагдуулсан орлогын орлон төлөгдөх аливаа татвар нь гэрээлэгчийн хувьд нэмэлт орлого болох бөгөөд энэхүү нэмэлт орлого нь орлогын орлон төлөгдөх татварт мөн адил хамаарагдана (энэ нь гэрээлэгчийн орлого нь МГТ компанийн хариуцан төлж барагдуулах татварыг багтаан "өснө" гэсэн үг болно).

Гэрээний 10.4 (б)-д тодорхойлсон гэрээлэгчийн татвар төлбөл зохих нийт орлогоос түүний өсөн нэмэгдсэн орлогын орлон төлөгдөх татвартай тэнцэх хэмжээний мөнгийг хасаад "Гэрээт орлого" үлдэнэ. "Өсөн нэмэгдсэн үнэ" гэдэг нь татвар төлөх орлогыг тооцоолж гаргахын тулд гэрээт орлого дээр нэмэх нэгэн хэмжээ болно. Ийнхүү өсөн нэмэгдсэн үнэ нь орлогын орлон төлөгдөх татвартай тэнцүү байна. Иймд:

Татвар төлөгдөх орлого = Гэрээт орлого + Өсөн нэмэгдсэн үнэ
Өсөн нэмэгдсэн үнэ = Татвар төлөх орлогод ногдох орлогын
орлон төлөгдөх татвар

Жишээлбэл, хэрэв орлогын орлон төлөгдөх татварт ногдох хувь тогтмол байвал,

Өсөн нэмэгдсэн үнэ = Татварт ногдох хувь х Татвар төлөх орлого

Эхний болон сүүлчийн тэгшитгэлийг нийлүүлбэл,

Өсөн нэмэгдсэн үнэ = Гэрээт орлого х татварт ногдох хувь

1 - татварт ногдох хувь

Дээрх тооцоог дараах тооны жишээгээр харуулбал, гэрээт орлого 10 доллар, татварт ногдох хувь 30 хувь гэж бодвол, өсөн нэмэгдсэн үнэ:

10 доллар х 0,3

----- : 4,29 доллар болно.

1-0,3

Жишээ:

Гэрээт орлого 10 доллар дээр нэмэх нь

Өсөн нэмэгдсэн үнэ 4,29 доллар, тэнцүү

Татвар төлөх орлого 14,29 доллар болно.

Үүнээс:

Монголын хуульд заасан татварын 30 хувь 4,29 долл. хасвал

Гэрээлэгчийн татвар төлсний дараах орлого 10 доллар гарна.

ТОСОН УУЛ-ХИХ ГЭРЭЭТ ТАЛБАЙН ТАЛААР
МОНГОЛ ГАЗРЫН ТОС КОМПАНИ БОЛОН
МЕДАЛЛИОН МОНГОЛ ОЙЛ КОМПАНИЙН ХООРОНД
1993 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДӨР БАЙГУУЛСАН
БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ
НЭМЭЛТ ХЭЛЭЛЦЭЭР


Нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар (цаашид "ГТХЭГ" гэх), нөгөө талаас 21/277 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ, 2075385 тоот Регистрийн дугаар, 771 тоот Гадаадын хөрөнгө сруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй "СОКО Тамсаг Монгол" ХХК (цаашид "Гэрээлэгч" гэх) (цаашид хамтад нь "Талууд" гэх) дор дурдсан зүйлийн талаар 2004 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1. Талууд "Газрын тосны тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Тосон уул-ХИХ гэрээт талбайн талаар Монгол Газрын тос компани болон Медаллион Монгол Ойл компанийн хооронд 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний эрэл, хайгуулын ажил явуулах хугацааг ГТХЭГ-аас сунгасан хугацаа дууссанаас хойш тав (5) хүртэл жилээр сунгахаар тохиролцов.
2. Гэрээлэгч нь БХГ-ний эрэл, хайгуулын ажил явуулах хугацааг Засгийн газраас сунгасантай холбогдуулан захиргааны үйлчилгээний шимтгэлд [redacted] ам. долларыг Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар хавсралтын II хэсгийн "в"-д заасны дагуу ГТХЭГ-т төлнө. Төлбөрийн эхний хэсэг болох [redacted] ам. долларыг Нэмэлт хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш арав (10) хоногийн дотор, үлдэх [redacted] ам. долларыг Нэмэлт хэлэлцээр хэрэгжиж эхэлснээс хойш арван тав (15) хоногийн дотор ГТХЭГ-т төлнө.
3. Гэрээлэгч нь Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 3 дугаар хавсралтын I хэсгийн "4"-т заасны дагуу Засгийн газрын шийдвэрээр сунгасан эрэл, хайгуулын таван (5) жилийн хугацаанд жил бүр гэрээт

талбайн нэг хавтгай дөрвөлжин километр газарт ногдох "газрын түрээсийн төлбөр"-ийн тарифыг [redacted] доллар байхаар тооцож, гэрээт жил эхэлснээс хойш гуч (30) хоногийн дотор тус тус ГТХЭГ-т төлнө.


4. БХГ-ний эрэл, хайгуулын ажил явуулах сунгасан таван (5) жилийн хугацаанд Гэрээлэгч жил бүр хавсралт "А"-д зааснаас багагүй хөрөнгийг наад захын ажил үүрэгт зарцуулна. Гэрээлэгч энэхүү үүргээ бүрэн биелүүлээгүй бол гүйцэтгээгүй ажилд ногдох зарцуулагдаагүй хөрөнгийг тухайн гэрээт жил дууссанаас хойш гуч (30) хоногийн дотор ГТХЭГ-т төлнө.
5. Талууд XIX талбайд хийж гүйцэтгэсэн ажил түүнд зарцуулсан болон өртөгт тосоор нөхөн төлөгдөх зардал, олборлосон ба экспортлосон газрын тос, бүтээгдэхүүн хуваалтын талаар Хавсралт "Б"-д үзүүлснээр харилцан тохиролцож баталгаажуулав.
6. Энэхүү Нэмэлт хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаанд 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан БХГ мөн адил хүчинтэй байна.
7. Энэхүү Нэмэлт хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбогдон Талуудын хооронд гарч болох маргааныг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
8. Энэхүү Нэмэлт хэлэлцээрийг англи, монгол хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүдийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.
9. Энэхүү хэлэлцээр нь 2005 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2010 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хүчинтэй байна.

ГТХЭГ-ЫН ДАРГА



О. ДАВААСАМБУУ

"СОКО ТАМСАГ МОНГОЛ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЭДВАРД СТОРИ